




УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР ТӨСӨЛ-ХОЁРДУГААР ҮЕ ШАТ

**“БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН
БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ ТӨСӨЛ”-ИЙН 2022 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 0004103 /

2022



**УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН
2-Р ҮЕ ШАТ**

**“БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН
БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ ТӨСӨЛ”-ИЙН 2022 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/ Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 0004103/

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР,
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ж.БАТЗОЛБОО

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ



Д.АВИРМЭД

“УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР” ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

З. МӨНХ-ОРГИЛ

БОЛОВСРУУЛСАН:

“ОД ДАЙНАМИК” ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Д.ДАВААМАА

УЛААНБААТАР 2022 ОН

**2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН:
“БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ” ТӨСӨЛ**

Журмын 4 дүгээр хавсралт.
Тухайн жилийн байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх,
хүлээж авах загвар

А. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх хуудас

д. Дэд бүтцийн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх хуудас

1. Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр: Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын дэмжих төсөл хэрэгжүүлэх нэгж
2. Төслийн байршил: Сонгинохайрхан дүүрэг 6, 24, 25, 40 дугаар хороо
3. Үйл ажиллагааны чиглэл: Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих
4. Огноо: 2022.11.28

#	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Авсан байвал зохих оноо	Ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн оноо							Гишүүдийн үнэлсэн онооны энгийн арифметик дундаж	Үндэслэл, тайлбар
			Гишүүн 1	Гишүүн 2	Гишүүн 3	Гишүүн 4	Гишүүн 5	Гишүүн 6	Гишүүн 7		
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	20	15	15	15	15	15	15	15		
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	30	25	25	25	25	25	25	25		
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	5	-	-	-	-	-	-	-		
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	15	15	15	15	15	15	15	15		
5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	10	10	10	10	10	10	10	10		
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	10	10	10	10	10	10	10	10		

7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5		
8	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнан төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5		
	Нийт оноо	100	90	90	90	90	90	90	90	90%	

Тайлбар: Бүрэлдэхүүн хэсэг тус бүрт биелэлтээс нь хамааран авсан байвал зохих оноог тогтоосон ба ажлын хэсгийн гишүүн тус бүрийн өгсөн онооны энгийн арифметик дунджийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрт тооцож гаргана. Гишүүдийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрт өгсөн онооны энгийн арифметик дунджийн нийлбэр нь нийт оноо болно. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийн биелэлтийн нийт оноо нь 95-аас доош байвал төлөвлөгөөний биелэлтийг хангалтгүй гэж үзнэ. Тухайн жилд дүйцүүлэн хамгаалах ажил төлөвлөгөөгүй бол нөхөн сэргээх арга хэмжээ рүү, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгөөгүй бол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт рүү шилжүүлж тооцно.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Мөнхбаяр (Гишүүн 1) /99112389/

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Ж.Батзолбоо (Гишүүн 2) /99198140/

Гишүүд:
Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын
Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч Б.Энхбат (Гишүүн 3) /99903391/

Туул голын сав газрын захиргааны
Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Энхбаяр (Гишүүн 4) /99596945/

Дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч Д.Баасанхүү (Гишүүн 5) /99045683/

Тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан байгаль хамгаалагч Д.Төмөрбаатар (Гишүүн 6) /94825488/

Нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл А.Хам-Огюм (Гишүүн 7) А.Хам-Огюм 80077335

Хүлээн зөвшөөрсөн:
Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр
төслийн зохицуулагч Д.Авирмэл



Агуулга

ТОВЧИЛСОН ҮГС	7
1 ТАНИЛЦУУЛГА	8
1.1 Ерөнхий мэдээлэл	8
1.2 Баянхошуу нийгмийн барилга байгууламжийн ажлын явц, байршил.....	9
1.3 Баянхошуу нийгмийн барилга байгууламж барих төслийн танилцуулга.....	12
1. 1.3.1ASKG гэрээний дугаартай 240 хүүхдийн цэцэрлэг	12
2. 1.3.2DDCD-BKH гэрээний дугаартай олон нийтийн хөгжлийн төв барих төсөл	14
3. 1.3.3SHS гэрээний дугаартай Зорилтот бүлгийн 126 айлын орон сууц төсөл	16
4. 1.3.4DDPK-BKH гэрээний дугаартай Баянхошуу дэд төвийн цэцэрлэгт хүрээлэнгийн төсөл	18
5. 1.3.5BDSC-BKH гэрээний дугаартай Спорт цогцолбор төсөл	19
6. 1.3.6HSSC-C гэрээний дугаартай салбар шугам барих төсөл	21
7. 1.3.7FSBKH гэрээний дугаартай Гал түмэр унтраах, аврах 29-р ангийн барилга төсөл	22
8. 1.3.8BKHS гэрээний дугаартай Баянхошуу амралтын талбай төсөл	24
2 БОМТ 2022 ОНЫ БИЕЛЭЛТИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ	26
3 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ БҮРЭЛДЭХҮҮН, НИЙТ ЗАРДАЛ	27
3.1 SHS гэрээний дугаартай Зорилтот бүлгийн 126 айлын орон сууц төсөл	27
9. 3.1.1BDSC-BKH гэрээний дугаартай Спорт цогцолбор төсөл	27
10. 3.1.2HSSC-C гэрээний дугаартай салбар шугам барих төсөл	27
3.2 ASKG гэрээний дугаартай 240 хүүхдийн цэцэрлэг	28
3.3 DDCD-BKH гэрээний дугаартай олон нийтийн хөгжлийн төв барих төсөл.....	28
3.4 DDPK-BKH гэрээний дугаартай Баянхошуу дэд төвийн цэцэрлэгт хүрээлэнгийн төсөл 29	
4 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	30
4.1 SHS гэрээний дугаартай Зорилтот бүлгийн 126 айлын орон сууц төсөл	30

11.	4.1.1Зорилтот бүлгийн 126 айлын орон сууц төслийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын дэлгэрэнгүй тайлан	36
4.2	Салбар шугамын холболт хийх HSSC-C багц.....	49
4.3	BDSC-BKH гэрээний дугаартай Спорт цогцолбор төсөл.....	58
5	НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ	62
5.1	Нөхөн сэргээлтийн ажил хийх талбайн хэмжээ	62
6	ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ	63
7	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	65
12.	7.1.1HSSC-C гэрээний дугаартай салбар шугам барих төсөл	66
Зураг 1.	нүүлгэн шилжүүлсэн 2 айлын нүхэн жорлонг ариутган дарж буй байдал	68
8	ОСОЛ ЭРСДЭЛ, ХИМИЙН БОДИСЫН МЕНЕЖМЕНТ, БИЕЛЭЛТ	69
8.1	SHS гэрээний дугаартай зорилтот бүлгийн орон сууц төслийн осол эрсдэл, химийн бодисын менежмент, биелэлт	69
8.2	BDSC-BKH гэрээний дугаартай Спорт цогцолбор төслийн осол эрсдэл, химийн бодисын менежмент, биелэлт	78
8.3	HSSC-C гэрээний дугаартай Салбар шугамын холболтын ажлууд төслийн осол эрсдэл, химийн бодисын менежмент, биелэлт.....	85
9	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	88
9.1	SHS гэрээний дугаартай Зорилтот бүлгийн орон сууц төслийн хог хаягдлын менежмент төлөвлөгөөний биелэлт	88
9.2	BDSC-BKH гэрээний дугаартай Спорт цогцолбор төслийн хог хаягдлын менежмент төлөвлөгөөний биелэлт	95
9.3	HSSC-C гэрээний дугаартай Салбар шугамын холболтын ажил төслийн хог хаягдлын менежмент төлөвлөгөөний биелэлт	98
	Ажилчдын кемпийн хогийн цэг	98
	Ажилчдын жорлон.....	98
	Хог хаягдлыг ачих болон буулгах үеийн зургууд /2022/.....	98
10	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	100
10.1	SHS гэрээний дугаартай Зорилтот бүлгийн орон сууц төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	101
10.2	BDSC-BKH гэрээний дугаартай Спорт цогцолбор төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	108

10.3	HSSC-C гэрээний дугаартай Салбар шугамын холболтын ажлийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	111
11	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	116
12	УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ, ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ	117
13	ХАВСРАЛТ БҮЛЭГ	119

ТОВЧИЛСОН ҮГС

АХБ - Азийн Хөгжлийн Банк

БОАЖЯ - Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам

БОМТ - Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө

БОМТБ - Т Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөөний биелэлтийн тайлан

БОХШХ - Байгаль Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр

БОНЕҮ - Байгаль Орчны Нөлөөллийн Ерөнхий Үнэлгээ

БОННҮ - Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээ

БОХХ - Байгаль Орчны Хөндлөнгийн Хяналт

БДТ - Баянхошуу Дэд Төв

ЕХО - Европын Хөрөнгө Оруулалтын Банк

ЗДХ - Зөвшөөрөгдөх Дээд Хэмжээ

МУИС - Монгол Улсын Их Сургууль

НЗДТГ - Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар

НБОГ - Нийслэлийн байгаль орчны газар

НӨ - Нөлөөлөлд Өртөх

СБДТ - Сэлбэ, Баянхошуу дэд төв

СЭС - Сошио Энвайронментал Сервис

СДТ - Сэлбэ Дэд Төв

ГХХХОДХ - Гэр Хорооллыг Хөгжүүлэх, Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Хөтөлбөр

ТУН - Төслийн Удирдах Нэгж

1 ТАНИЛЦУУЛГА

1.1 Ерөнхий мэдээлэл

Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр Нийслэлийн Засаг Даргын Тамгын газарт хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл нь Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага баримт бичгийн дагуу хотын гэр хорооллын дэд бүтэц, нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулах, тогтвортой хөгжүүлэхэд чиглэгдсэн арван жилийн хугацаатай хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл юм.

Энэхүү хөтөлбөрөөс хүлээгдэж буй үр дүн, нөлөөлөл нь Улаанбаатар хотын амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах явдал юм. Энэхүү хөтөлбөрийн гол зорьж буй үр дүн нь Улаанбаатар хотын гэр хорооллыг тогтвортой, олон талыг хамардаг, сайн-бүтэцтэй болгон хөгжүүлэх явдал юм. Хөтөлбөрөөс гарах үр дүн нь:

- (i) Эдийн засгийн боломжууд, байшин барилга барих, хөдөлмөр эрхлэх боломж олгох, байгаль орчинд үүсэх нөлөө, тухайлбал: хөрс, агаарын бохирдолтой холбогдох нөлөөг багасган дэд төвүүдийг хөгжил сайтай бүс болгох
- (ii) Ус хангамж, бохир ус, дүүргийн халаалтын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг санхүүгийн хувьд бие даасан өндөр чанартай үйлчилгээ үзүүлдэг болгох зорилгоор орчин үеийн тоног төхөөрөмж ашиглах боломжтой болгох;
- (iii) Зах зээлийн таатай орчин, зохистой хууль эрх зүйн орчинд үндэслэсэн оновчтой, олон нийтээр идэвхтэй оролцдог өсөлтөд чиглэсэн хот төлөвлөлтийн тогтолцоог бий болгох зэрэг юм.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн 2-р үе шатанд Баянхошуу-Ханын материалд хүүхдийн цэцэрлэг, спорт цогцолбор, эмзэг давхаргын өрхүүдэд зориулсан түрээсийн орон сууц, иргэний хөгжлийн төв, бичил цэцэрлэгт хүрээлэн зэрэг нийгэм, олон нийтэд үйлчлэх барилга, байгууламжийг барих ажлыг хийхээр төлөвлөсөн байна.

2022 оны 11 дугаар сарын байдлаар Баянхошуу нийгмийн барилга байгууламж барих төсөлд хамаарагдах нийт 8 төслийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалт явагдахаас. Ковид болон барааны үнийн өсөлтөөс шалтгаалж 3 төслийн барилга байгууламжын ажил 2021 оны 8-р сараас эхэлж зогссон байгаа бол 3 төслийн

барилга байгууламжийн ажил хэвийн явагдаж байгаа ба 2 төсөл тендерийн шалгаруулалтын явцадтай байна.

Баянхошуу нийгмийн барилга байгууламж барих төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ) 2020 онд хийгдэж, БОАЖЯ-аар батлагдсан. энэхүү төрийн захиргааны байгууллагаас батлагдсан төлөвлөгөөний дагуу Баянхошуу нийгмийн барилга байгууламжын ерөнхий БОМТ 2021 оны биелэлт, хэрэгжилтийн тайланг 2019 оны 10-р сарын 29-ны өдөр Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яам (БОНХЯ)-ны сайдын баталсан *“Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”* А-618 дагуу боловсруулав.


1.2 Баянхошуу нийгмийн барилга байгууламжийн ажлын явц, байршил

Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төслийн хүрээнд шинээр баригдах дараах барилга байгууламжууд, тэдгээрийн хэрэгжих орчныг дараах газрыг хамрах болно. Үүнд:

1. Сонгинохайрхан дүүргийн 40-р хороонд баригдах 240 хүүхдийн цэцэрлэг
2. Сонгинохайрхан дүүргийн 40-р хороонд баригдах "Олон нийтийн хөгжлийн төв"
3. Сонгинохайрхан дүүргийн 40-р хороонд баригдах Спорт цогцолбор
4. Сонгинохайрхан дүүргийн 40-р хороонд баригдах Гал унтраах, аврах 29-р ангийн барилга
5. Сонгинохайрхан дүүргийн 6-р хороонд баригдах Зорилтот бүлгийн орон сууц
6. Сонгинохайрхан дүүргийн 24, 25-р хороонд баригдах Баянхошуу цэцэрлэгт хүрээлэн
7. Сонгинохайрхан дүүргийн 24 хороонд баригдах Баянхошуу талбай
8. Сонгинохайрхан дүүргийн 40-р хороонд баригдах Спорт цогцолбор, Олон нийтийн хөгжлийн төв, 240 хүүхдийн цэцэрлэгийн барилгуудыг цэвэр бохир усны төвлөрсөн шугамд холбох, Баянхошуу дэд төвд дулааны салбар шугамын холболт угсралтын ажлууд хийх

“Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих” төслийн хүрээнд барьж байгуулах объектуудын мэдээллийг доорх хүснэгтэд хураангуйлан үзүүлэв.

Зураг 1-1. “Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих” төсөл хэрэгжих талбайн байршил




2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ” ТӨСӨЛ

Хүснэгт 1-1. Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төслийн барьж байгуулах объектууд

№	Гэрээний дугаар	Шинээр баригдах нийгмийн байгууламжууд	Хүчин чадал, хэмжээ	2022 онд барилгын ажил явагдах хугацаа			2022 оны барилгын ажлын явц	Гүйцэтгэгч
				Эхлэх	Дуусах	Үргэлжлэх		
1	ASKG-BKH	Хүүхдийн цэцэрлэг	240 ортой, 2 давхар барилга	2021.04.01	2022.10.31	17 сар	16% Барилгын ажил зогссон	“Цаст констракшн” ХХК
2	DDCD-BKH	Олон нийтийн хөгжлийн төв	Сургалт хурлын заалт 2 давхар барилга	2021.04.01	2022.10.31	17 сар	15% Барилгын ажил зогссон	“Тэш-Агь констракшн” ХХК
3	BDSC-BKH	Спорт цогцолбор	610 хүний суудалтай спорт заал, усан бассейн, бөх, бокс, фитнес танхимуудтай	2022.04.01	2022.10.31	15 сар	25%	Стандарт Холдинг ХХК-
4	FSBKH	Гал түмэр унтраах, аврах 29-р ангийн барилга	Оффис, граж, агуулах зэрэг 3 барилга байгууламж шинээр барина.	2021.06.01	2022.10.31	15 сар		-
5	DDPK-BKH	Баянхошуу цэцэрлэгт хүрээлэн	Ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай	2021.04.01	2022.10.31	17 сар	60% Барилгын ажил зогссон	“Дүүрэн Трейд” ХХК
6	SHS	Зорилтот бүлгийн орон сууц	9 давхар 2 барилга, тус бүр 63 айл	2021.04.01	2022.10.31	17 сар	80%	“Монкон констракшн” ХХК
7	HSSC-C	Салбар шугамын холболтын ажлууд	Баянхошуу дэд төвд буй нийгмийн барилгуудыг цэвэр, бохир ус, дулаан, цахилгааны төвлөрсөн шугамд холбох ажлууд	2022.04.01	2023.10.31	15 сар	40%	“Эс энд эй трейд” ХХК -
8	/BKHS/	Баянхошуу талбай	4,2 га талбайд амаралтын талбай байгуулна.	2022.04.01	2022.10.31	15 сар	Барилгын ажил эхлээгүй	-
	Барилгын ажил зогссон	Барилгын ажил хэвийн явагдаж байгаа	Барилгын ажил эхлээгүй					

Зураг 1-2. Барилгын ажлын явц



1.3 Баянхошуу нийгмийн барилга байгууламж барих төслийн танилцуулга

1.3.1 ASKG гэрээний дугаартай 240 хүүхдийн цэцэрлэг

Агуулга	Утга
Дэд төвийн нэр:	Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төсөл.
Төслийн нэр:	ASKG гэрээний дугаартай 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажил
Төслийн захиалагч:	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
Төсөл хэрэгжүүлэгч:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр 2 дугаар үе шат”
Төслийн туслан гүйцэтгэгч:	“Цаст констракшн” ХХК. Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 9011044119, регистрийн дугаар 2791668.
Төсөл хэрэгжих хугацаа:	2021-2022 он /2 жил/ Барилгын үнийн өсөлтөөс шалтгаалж 1 жил барилгын ажил зогссон байна.
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян гүний гудамж, Өөрийн байр-4, Утас1: 320444, 311251, утас2: 99116282, факс: 311251
Төслийн барилга угсралтын явц:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-н хүрээнд хийгдэж буй “Сонгинохайрхан дүүргийн 40-р хороонд 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Барилгын төмөр бетон каркасны ажил 40%-тай хийгдэж байна. Нийт БУАжил нь 16%-тай явж байна

240 Хүүхдийн цэцэрлэгийн харагдах байдал	
240 хүүхдийн цэцэрлэг барих талбайн барилга барихаас өмнөх байдал	
240 хүүхдийн цэцэрлэг барих талбайн өнөөгийн байдал	
240 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих талбайн сансарын зураг	

1.3.2 DDCCD-BKH гэрээний дугаартай олон нийтийн хөгжлийн төв барих төсөл

Агуулга	Утга
Дэд төвийн нэр:	Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төсөл.
Төслийн нэр:	DDCCD-BKH гэрээний дугаартай олон нийтийн хөгжлийн төв барих төсөл
Төслийн захиалагч:	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
Төсөл хэрэгжүүлэгч:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр 2 дугаар үе шат”
Төслийн туслан гүйцэтгэгч:	“Тэш-Агь констракшн” ХХК. Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 9011454143, регистрийн дугаар 5801923.
Төсөл хэрэгжих хугацаа:	2021-2022 он /2 жил/ Барилгын үнийн өсөлтөөс шалтгаалж 1 жил барилгын ажил зогссон байна.
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Баянзүрх дүүрэг, 18-р хороо, 13-р хороолол 39-48 тоот , Утас1: 88084640, 399007069
Төслийн барилга усралтын явц:	“Тэш Агь констракшн” ХХК болон “Ай Ди Си проперти” ХХК –ийн түншлэлийн гүйцэтгэж байгаа “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-н хүрээнд хийгдэж буй “Сонгинохайрхан дүүргийн 40-р хороо, “ОЛОН НИЙТИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” –ийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл нь 15%-тай явагдаад байна
Олон нийтийн хөгжлийн төвийн харагдах байдал	

Олон нийтийн хөгжлийн
төвийн барилга
барихаас өмнөх байдал



Олон нийтийн хөгжлийн
төв барих талбайн
өнөөгийн байдал



ОНХТ барилга барих
талбайн сансарын зураг



1.3.3 SHS гэрээний дугаартай Зорилтот бүлгийн 126 айлын орон сууц төсөл

Агуулга	Утга
Дэд төвийн нэр:	Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төсөл.
Төслийн нэр:	SHS гэрээний дугаартай Зорилтот бүлгийн 126 айлын орон сууц төсөл
Төслийн захиалагч:	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
Төсөл хэрэгжүүлэгч:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр 2 дугаар үе шат”
Төслийн туслан гүйцэтгэгч:	“Монкон констракшн” ХХК. Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 9011229115, регистрийн дугаар 5372852
Төсөл хэрэгжих хугацаа:	2021-2023он /3 жил/
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	СБД, 1 хороо, Олимпын гудамж, Нью Хоризонс Оффис, 12 давхар
Төслийн барилга усралтын явц:	“Монкон Констракшн” ХХК-ийн гүйцэтгэж байгаа “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-н хүрээнд хийгдэж буй “Сонгинохайрхан дүүргийн 6-р хороо, ханын материал орчимд баригдах 9 давхар, 2 блок нийт 126 айлын түрээсийн орон сууцны барилга угсралтын ажлын гүйцэтгэл нь 80%-тай явагдаад байна
Зорилтот бүлгийн орон сууцийн харагдах байдал	
Зорилтот бүлгийн орон сууцийн барилга барихаас өмнөх байдал	

**Зорилтот бүлгийн орон
сууцийн барилга барих
талбайн өнөөгийн
байдал**



**Зорилтот бүлгийн орон
сууцны барилга барих
талбайн сансарын
зураг**



УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР, 2 ДУГААР
ҮЕ ШАТ ХУУДАС- 18

Соёл амралтын хүрээлэнгийн барилга барихаас өмнөх байдал	
Соёл амралтын хүрээлэнгийн барилга барих талбайн өнөөгийн байдал	
Соёл амралтын хүрээлэнгийн сансарын зураг	

1.3.5 BDSC-BKH гэрээний дугаартай Спорт цогцолбор төсөл

Агуулга	Утга
Дэд төвийн нэр:	Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төсөл.
Төслийн нэр:	BDSC-BKH гэрээний дугаартай Спорт цогцолборын төсөл
Төслийн захиалагч.	Нийслэлийн Засаг даргын тамгын газар

Төсөл хэрэгжүүлэгч:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх,хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр 2 дугаар үе шат”
Төслийн туслан гүйцэтгэгч:	JV of Standard Holding LLC, Himon Construction LLC and Tanii Zam LLC
Төсөл хэрэгжих хугацаа:	2022 оноос барилгын ажил эхэлж 2023 ондоо дуусгах болно
Төслийн барилга усралтын явц:	Барилгын үндсэн карказын ажлыг хийж байгаа.Барилгын ажлын 25% явагдаж байна
Спорт цогцолборын харагдах байдал	
Спорт цогцолборын барилга барихаас өмнөх байдал	
Спорт цогцолборын барилга барих талбайн өнөөгийн байдал	



1.3.6 HSSC-C гэрээний дугаартай салбар шугам барих төсөл

Агуулга	Утга
Дэд төвийн нэр:	Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төсөл.
Төслийн нэр:	HSSC-C гэрээний дугаартай салбар шугам барих төсөл
Төслийн захиалагч:	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
Төсөл хэрэгжүүлэгч:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх,хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр 2 дугаар үе шат”
Төслийн туслан гүйцэтгэгч:	“Эс энд эй трейд” ХХК
Төсөл хэрэгжих хугацаа:	2022 оны 4-р сард эхэлсэн 2023 онд дуусах болно.
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 8-1 тоот
Төслийн барилга усралтын явц:	Газар шорооны ажлын хүрээнд гудамж талбайн шугам тавих ажил хийгдэж дууссан. Узелийн барилгын ажил бусад холболтын ажил хийгдэнэ.Барилгын ажлын явц 40% явагдаж байна.

**Салбар шугамын
холболтын
ажлууд
сансарын зураг**



УДДТөвийн барилга



1.3.7 FSBKH гэрээний дугаартай Гал түмэр унтраах, аврах 29-р ангийн барилга төсөл

Агуулга	Утга
---------	------


Дэд төвийн нэр:	Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төсөл.
Төслийн нэр:	FSBKH гэрээний дугаартай Гал түмэр унтраах, аврах 29-р ангийн барилга төсөл
Төслийн захиалагч.	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
Төсөл хэрэгжүүлэгч:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх,хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр 2 дугаар үе шат”
Төслийн туслан гүйцэтгэгч:	
Төсөл хэрэгжих хугацаа:	2023-2024 онд
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	
Төслийн барилга усралтын явц:	Сонгон шалгаруулалт явагдаагүй байгаа. Барилгын ажил эхлээгүй
Гал түмэр унтраах, аврах 29-р ангийн харагдах байдал	
Гал түмэр унтраах, аврах 29-р ангийн барилга барихаас өмнөх байдал	



1.3.8 ВКНС гэрээний дугаартай Баянхошуу амралтын талбай төсөл

Агуулга	Утга
Дэд төвийн нэр:	Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төсөл.
Төслийн нэр:	ВКНС гэрээний дугаартай Баянхошуу амралтын талбай төсөл
Төслийн захиалагч.	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
Төсөл хэрэгжүүлэгч:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх,хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр 2 дугаар үе шат”
Төслийн туслан гүйцэтгэгч:	-
Төсөл хэрэгжих хугацаа:	-
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	-
Төслийн барилга усралтын явц:	Сонгон шалгаруулалт явагдаагүй байгаа. Барилгын ажил эхлээгүй

Баянхошуу
амралтын
талбайн
сансарын зураг



2 БОМТ 2022 ОНЫ БИЕЛЭЛТИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

БОМТ нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төслийн талбай, түүний орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, хянах үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. Энэхүү төлөвлөгөөний биелэлтийг хянуулж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- БОМТ-д тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажилчдын үүрэг хариуцлагын тогтоосон удирдлагын шатлал дараалал бий болно.
- Ажилчид бүр байгаль орчныг хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхын зэрэгцээ тэдэнд биелүүлэхэд нь туслах бэлтгэл сургалт, ур чадвартай мэргэжилтэнтэй болсон байна.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдлийг урьдчилан тооцож, байгаль орчинд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, орчны чанарыг сайжруулах, хэвийн нөхцөлийг хадгалж, хамгаална.
- Орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, иргэдтэй байгаль орчныг хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний санал, хүсэлтийг хүлээн авч, хамтран ажиллана.
- Байгаль орчны асуудлаарх төрийн захиргаанаас өгсөн санал зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

НБОГ нь тухайн төслийн БОМТ-ийн биелэлтийн тайлантай танилцан хянаж ажиллана. БОМТ-ий биелэлт, хэрэгжилтэнд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, БОАЖЯ болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй бөгөөд тэдгээрт холбогдох мэдээллээ ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх нь төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг болно.

3 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ БҮРЭЛДЭХҮҮН, НИЙТ ЗАРДАЛ

3.1 SHS гэрээний дугаартай Зорилтот бүлгийн 126 айлын орон сууц төсөл

Хүснэгт 3-1. Зорилтот бүлгийн 126 айлын орон сууц төслийн зардлын хураангуй

№	Байгаль орчны бүрдэл хэсэг	Төлөвлөгөө /төг/	Гүйцэтгэл /төг/
1	Сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	425,000	43 029 577,6
2	Нөхөн сэргээлтийн зардал	12,012,500	Тайлант онд хийгдээгүй
3	Биологийн олон янж байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	-	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-	-
6	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	1 650 000	280 000.00
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,528,625	450 000.00
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1 650 000	810 600.00
Нийт		17,266,125	44 570 177,6

3.1.1 BDSC-BKH гэрээний дугаартай Спорт цогцолбор төсөл

№	Байгаль орчны бүрдэл хэсэг	Төлөвлөгөө /төг/	Гүйцэтгэл /төг/
1	Сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,370 000	
2	Нөхөн сэргээлтийн зардал	6,329,080	Тайлант онд хийгдээгүй
3	Биологийн олон янж байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	-	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-	-
6	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	1,650,000	
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,528,625	
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,650,000	
Нийт		12,527,705	

3.1.2 HSSC-C гэрээний дугаартай салбар шугам барих төсөл

№	Байгаль орчны бүрдэл хэсэг	Төлөвлөгөө /төг/	Гүйцэтгэл /төг/
1	Сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3,810,000	

2	Нөхөн сэргээлтийн зардал	-	Тайлант онд хийгдээгүй
3	Биологийн олон янк байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	-	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-	-
6	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	1,650,000	
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,528,625	
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3,550,000	
Нийт		10,538,625	

3.2 ASKG гэрээний дугаартай 240 хүүхдийн цэцэрлэг

Хүснэгт 3-2. 240 хүүхдийн цэцэрлэгийн зардлын хураангуй

№	Байгаль орчны бүрдэл хэсэг	Төлөвлөгөө /төг/	Гүйцэтгэл /төг/
1	Сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	629 450	Үнийн өсөлтөөс шалтгаалж 2021 оны 8-р сараас хойш барилгын ажил зогссон байгаа
2	Нөхөн сэргээлтийн зардал	7,230,380	
3	Биологийн олон янк байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	-	
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-	
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-	
6	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	1,650,000	
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,528,625	
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,650,000	
Нийт		12,684,455	

3.3 DDCD-BKH гэрээний дугаартай олон нийтийн хөгжлийн төв барих төсөл

Хүснэгт 3-3. Олон нийтийн хөгжлийн төв барих төслийн зардлын хураангуй.

№	Байгаль орчны бүрдэл хэсэг	Төлөвлөгөө /төг/	Гүйцэтгэл /төг/
1	Сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	846,750	Үнийн өсөлтөөс шалтгаалж 2021 оны 8-р сараас хойш барилгын ажил зогссон байгаа
2	Нөхөн сэргээлтийн зардал	11,183,06 0	
3	Биологийн олон янк байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	-	
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-	
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-	
6	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	1,650,000	
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,528,625	

8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,650,000	
Нийт		16,855,435	

3.4 DDPK-BKH гэрээний дугаартай Баянхошуу дэд төвийн цэцэрлэгт хүрээлэнгийн төсөл

№	Байгаль орчны бүрдэл хэсэг	Төлөвлөгөө /төг/	Гүйцэтгэл /төг/
1	Сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4,260,000	Үнийн өсөлтөөс шалтгаалж 2021 оны 8-р сараас хойш барилгын ажил зогссон байгаа
2	Нөхөн сэргээлтийн зардал	6,272,625	
3	Биологийн олон янж байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	-	
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-	
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-	
6	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	1,650,000	
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,528,625	
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2,150,000	
Нийт		15,861,250	

4 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

4.1 SHS гэрээний дугаартай Зорилтот бүлгийн 126 айлын орон сууц төсөл

Хүснэгт 4-1. Зорилтот бүлгийн 126 айлын орон сууц төслийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан.

№	Сөрөг нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Ажлын хэмжээ	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/
1. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт				
1	Төлөвлөгөөнд тусгагдсан тоо хэмжээ болох 0.06га талбайд барилга угсралтын ажил хийгдэж суурийн эргэн булалтын ажил, гадна барилга угсралтын ажил хийгдэж дууссан. Дотоод заслын 80%-тай үргэлжилж байна. Тайлант оны 11 сард комисс ажиллуулахаар төлөвлөн ажиллаж байна. Барилга угсралтын ажил дууссаны дараа орчны тохижилт, ногоон байгууламжийн ажлыг захиалагч талаас тавьсан шаардлага, тоо хэмжээ болон МУ-д мөрдөгдөж буй стандарт нормын дагуу хийж гүйцэтгэх болно.	Ногоон байгууламж, тохижилтийг барилгын ажил дууссаны дараа хийж гүйцэтгэнэ.	Төлөвлөгөөнд ногоон байгууламжийн ажлын зардалд тусгасан.	Барилгын ажил дуусаагүй тул хийгдээгүй.
2	Төслөөс үүсэх газар шорооны ажлаас гарах хаягдал шороог төслийн хашааны гадна талд түр овоолго үүсгэн хадгалсан. Төслийн барилгын ажил дууссаны дараа орчны тохижилт болон авто замын тэгшилгээнд ашиглах ба илүү гарсан шороог зөвшөөрөлтэй цэгт зайлуулах ажлыг зохион байгуулж ажиллах болно. Барилгын материалын хаягдал, ахуйн хог хаягдлыг зайлуулж ажиллах гэрээг 2021 онд Сонгино хайрхан дүүргийн тохижилт цэвэрлэгээ үйлчилгээний ОНӨААТҮГазартай байгуулж ажилласан ба тайлант 2022 онд сунгалтыг хийж ажиллалаа. Хаягдал шороог талбайн тэгшилгээнд ашигласны дараа зайлуулах арга хэмжээг авч, ТУН-д тайлагнаж ажиллах болно.	Хаягдал шороог төслийн талбайгаас зөөгдөх ажил хийгдээгүй.	Үйл ажиллагааны зардалд тусгасан.	-
3	Барилгын суурийн ажлын газар шорооны ажлаас гарсан хаягдал шороог барилгын үйл ажиллагаа явагдаж буй талбайн гадна талд явган хүний гарц, автомашины хөдөлгөөнд саад учруулахгүйгээр овоолго үүсгэн түр хадгалж ажилласан. Хаягдал овоолгыг зайлуулсаны дараа ойр орчмыг техникээр тэгшилж, цэвэрлэгээг хийж, нөхөн сэргээж ажиллах болно.		Нөхөн сэргээлт, тохижилтын ажлын төлөвлөгөөнд багтсан.	-
Нийт төсөв			-	-
2. Агаар орчин хамгаалах чиглэлээр авч хэмжээний биелэлт				

**2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН
БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ” ТӨСӨЛ**

4	2021 онд цаг уурын нөхцөл байдалд тулгуурлан талбайн усалгааг 2021.06.02-2021.09.15 хугацаанд нийт 14 удаа 3,1м³ усаар усалгаа хийх ажлыг зохион байгуулж ажиллав. Төслийн хэмжээнд боловсон 00 болон талбайн усалгаанд ашиглах усыг зөөврөөр гэрээгээр хангаж ажилласан. Гэрээнд 2.5тн усыг 29240төг байхаар гэрээнд тусгасан. Тайлант 2022 онд хур бороо ихтэй жил байсан тул талбайн усалгаа хийгдээгүй.	Усалгаанд 3.1 м3 усыг ашигласан байна.	Талбайн усалгаа - 546,750.00 Овоолго бүтээх – 750,000.00	Усалгааны зардал- 36257,6төг Овоолгыг бүтээх ажил хийгдээгүй.
5	Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн техникийн байдал, хэрэглээний стандартын үзүүлэлтийг хангуулах, автотээврийн хэрэгслээс хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг үр дагаврыг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг, оношлогоог явуулдаг. Техникийн хяналтын үзлэг, оношлогоо хийх тусгай зөвшөөрөл бүхий оношлогооны төв нь Автотээврийн тухай хуулийн 17.1-д заасны дагуу техникийн хяналтын үзлэг, оношлогоо хийж, зохих стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгсэлд замын хөдөлгөөнд оролцох эрхийн гэрчилгээ олгодог. Уг гэрчилгээг авсан техникүүдийг барилгын талбайд ажиллуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Мөн ОХШХ-т агаарын хяналт шинжилгээг мэргэжлийн байгууллага болох БОХЗТЛабораториор 6 болон 8 сард хийлгүүлж ажилласан. Уг шинжилгээний дүнгээс харахад хүхэрлэг хий, азотын давхар исэлийн хэмжээ ЗДХ-нээс хэтрээгүй үзүүлэлттэй байна. /2021, 2022 оны шинжилгээний дүнг ОХШХ-өөс харах/	Агаарын шинжилгээг 6, 8 саруудад 2 удаа мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж ажиллав.	ОХШХ-т тусгасан.	-
6	Барилгын ажлын талбайн журмын 6.1-т заасны дагуу талбайн өдөр тутмын цэвэрлэгээг ажил тарахаас 30 минутын өмнө талбайн инженер болон ХАБЭА-н инженер хариуцан тогтмол хийлгүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна.	Тогтмол хийлгүүлж ажиллав.	Үйл ажиллагааны зардалд тусгасан	-
Нийт			1,296,750.00	36257,6
3. Физик орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт				
7	Барилга угсралтын ажил 1 ээлжээр буюу 09:00-18:00 цагийн хооронд явагдсан. Төслийн талбайд өдрөөр зам талбайн бетон зуурмагийн машин, бусад туслан гүйцэтгэгч нарын техникүүд болон үйлчилгээний зөвшөөрөгдсөн машинууд нэвтрэх эрхтэй байдаг. Төсөл хэрэгжих хугацаанд төслийн талбайд эвдэрсэн, гэмтэлтэй техник ажиллаагүй. Уг тээврийн хэрэгслийн жолооч нарт ажил гүйцэтгэх хугацаанд зөвхөн шаардлагатай тохиолдолд дуут дохио ашиглах талаар зааварчилгаа өгч ажиллалаа. Төслийн талбайд дуут дохио	Дуу чимээний хэмжилтийн дүнг ОХШХ-т үзүүлэв.	ОХШХ-т тусгасан	-

2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ” ТӨСӨЛ

	ашиглахыг хориглосон тэмдэг тэмдэглэгээг барилгын ажил явагдаж буй хашааны хаалганы үүдэнд байршуулан ажиллаж байна. Төслийн хугацаанд 2021, 2022 онуудад дуу чимээний хэмжилтийг 6 болон 8 саруудад ОХШХ-т тусгасны дагуу 2 удаа хийлгүүлж ажиллав.			
8	2021.06.10-ны өдөр хог хаягдлын гэрээг Сонгино хайрхан дүүргийн тохижилт цэвэрлэгээ үйлчилгээний ОНӨААТҮГазартай байгуулж ажилласан. Тайлант онд 2022.06.15-ны өдөр тус гэрээг сунгаж ажиллав. /Гэрээг хавсралт хэсэгт хавсаргав. Хог хаягдал ба түүний менежмент гэдэг нь аливаа хог хаягдлыг ялгах – цуглуулах – зайлуулах – цэвэрлэх - халдваргүйжүүлэх цогц арга хэмжээг хэлдэг. Иймд бид төслөөс гарч буй хог хаягдлын ангилан ялгах цэгийг байгуулж, хашаажуулах, тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хог хаягдлыг түр цуглуулах арга хэмжээг авч ажиллаж байна. Барилгын үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлыг (мод, төмөр, хуванцар сав) түр цуглуулах цэгт хадгалан ажиллаж байна. Төслөөс гарч буй модны хаягдлыг нийгмийн хариуцлагын хүрээнд хорооны эмзэг бүлгийн айлуудад (түлшний зориулалтаар) өгөх ажлыг зохион байгуулж ажилласан. Төмрийн хаягдлын хэмжээ бага тул түр цуглуулах цэгт хадгалагдаж байна. Ахуйн хатуу хог хаягдлыг ОХӨААТҮГазартай байгуулсан гэрээний дагуу зайлуулах арга хэмжээг авч ажиллаж байна. Төслийн үйл ажиллагаанаас гарч буй шингэн хог хаягдлыг төвийн шуамд хийлүүлэн ажиллаж байна. Шаардлагатай цэгүүдэд хогийн савнуудыг хангалттай байршуулах ажлыг зохион байгуулж ажилласан.	-	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	-
Нийт			-	-
4. Гадаргын ба газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт				
9	Манай компани нь БО-ны журмыг дотооддоо боловсруулан батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг. Уг журманд асгаралт, түүнээс урьдчилан сэргийлэх, бохирдол үүссэн тохиолдолд авах хариу арга хэмжээ, хог хаягдлын хяналтын тухай тодорхой тусгасан байдаг. Барилга баригдаж буй төслийн талбайд гэрээгээр газар шорооны ажлын үед эксковатор, бетон цутгалтын үед бетон зуурмагийн машинууд болон барилгын материал буулгаж буй машинууд тодорхой хугацаанд нэвтрэн, ажил үүргийг гүйцэтгэн ажилласан. Төслөөс 50м-ын зайд “МТ” ШТС үйл ажиллагаа явуулдаг тул төслийн талбайд түлш цэцэглэх болон ШТМ-ын асгаралт үүссэн тохиолдолд бүртгэгдээгүй. Хэрэв үүссэн тохиолдолд журмын хавсралт-2-ын дагуу бүртгэлжүүлж, хариу арга хэмжээ авч ажилладаг.	-	50,000.00	-
10	Унд ахуй, талбайн усалгаа, ариун цэврийн өрөө, боловсон 00-д ашиглах усыг гэрээгээр зөөврөөр хангаж ажиллаж байна. Зөөврийн уснаас дээж	Хүснэгт-4.3-г харах	Үйл ажиллагааны зардалд тусгасан.	-

**2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН
БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ” ТӨСӨЛ**

	авч мэргэжлийн байгууллага болох БОХЗТЛабораториар шинжлүүлэн ажилласан. Шинжилгээний дүнгээс харахад ЗДХ-нээс хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна. /2021, 2022 оны шинжилгээний дүнг ОХШХ-өөс харах/			
11	Төслөөс үүсэх шингэн хог хаягдлыг гэрээгээр төвийн шугамд холбуулан зайлуулах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Боловсон ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийг (хлорамин болон жавелин) өдөр бүр хийлгүүлэн ажиллаж байна. (Бохир зайлуулах гэрээг хавсралт хэсэгт хавсаргав.)	-	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	-
Нийт			50,000.00	0,0
5. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт				
12	Тайлант хугацаанд барилгын сууриас гарсан хаягдал шороог зайлуулах ажил хийгдээгүй. Гадна талбайн тохижлт, машины зогсоол, тэгшлэх шаардлагатай газруудад дэвсгэлт хийсний дараа үлдэгдэл шороог зайлуулах арга хэмжээг авч ажиллана. Хаягдал шороог зайлуулахдаа ТУН-ээс тавьсан шаардлагын дагуу тогтсон маршрут, бүтээлэгтэй тэвэрээр зөөвөрлөж, үйл явцыг ТУН-д танилцуулж ажиллах болно.	-	Нөхөн сэргээлт, тохижилтын ажлын төлөвлөгөөнд тусгасан.	-
13	Төслийн талбайд шимт хөрс байхгүй. Тохижилт, ногоон байгууламжийн ажлыг хийхэд гаднаас шимт хөрс авч хийнэ.	-	Нөхөн сэргээлт, тохижилтын ажлын төлөвлөгөөнд тусгасан.	-
14	Төслийн талбайгаас 50м зайд “МТ-ШТС” байрлах тул төслийн талбайд техникүүд түлш цэнэглэх асуудал байхгүй. Харин төслийн талбайд нэвтэрч буй техникүүдэд талбайн журмын 5.1 заасны дагуу тойрох үзлэг хийж, шаардлага хангасан техникүүдийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа. Үйл ажиллагааны туршид хөрсөнд ШТМ асгарсан тохиолдол бүртгэгдээгүй.	-	Үйл ажиллагааны зардалд багтсан.	
15	Хог хаягдлын менежментийн дагуу хог хаягдлын ангилан ялгах түр цэгийг байгуулж, хашаажуулж, тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллав. /Хог хаягдлын тайланд тодорхой тусгав. Хог хаягдлын тайланг харах/	-	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	-
Нийт			-	-
6. Нийгэм, олон нийтэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт				
16	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт хэсгийн 4-т тодорхой тайлагнасан.	-	Энэхүү төлөвлөгөөний 2-р хэсэгт заагдсан төсвийн хүрээнд	-
17	Барилга угсралтын ажил 1 ээлжээр буюу 09:00-18:00 цагийн хооронд явагдсан. Төслийн талбайд өдрөөр бетон зуурмагийн машин, бусад	Физик нөлөөллийн 7-г харах	ОХШХ-т тусган оруулсан	-

2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ” ТӨСӨЛ

	туслан гүйцэтгэгч нарын техникүүд болон үйлчилгээний зөвшөөрөгдсөн машинууд нэвтрэх эрхтэй тул уг тээврийн хэрэгслийн жолооч нарт ажил гүйцэтгэх хугацаанд зөвхөн шаардлагатай тохиолдолд дуут дохио ашиглах талаар зааварчилгаа өгч ажиллалаа. Төслийн талбайд дуут дохио ашиглахыг хориглосон тэмдэг тэмдэглэгээг барилгын ажил явагдаж буй хашааны хаалганы үүдэнд байршуулан ажилласан.			
18	Барилгын сууриас гарч буй хаягдал шороог барилгын үйл ажиллагаа явагдаж буй талбайн гадна талд явган хүний гарц, автомашины хөдөлгөөнд саад учруулахгүйгээр түр овоолго үүсгэн хадгалсан. Ойр орчмын оршин суугчид болон иргэдээс гомдол санал ирээгүй.	-	Үйл ажиллагааны зардалд багтсан	-
19	Барилгын ажил явагдаж буй талбайг өндөр хашаагаар тусгаарлан, хашааны үүд үүд болон эргэн тойронд барилгын ажил явагдаж буйг илтгэх тэмдэг тэмдэглэгээг байршуулан ажилласан. Мөн хашааны хаалганд төслийн танилцуулга болон санал гомдол хүлээж авах холбогдох хүмүүсийн утасны дугаарыг байршуулан ажилласан. Түр хашааг “Говелган” ХХК бэлтгэн нийлүүлж ажилласан. Гэрээ болон төлбөрийн баримтыг хавсаргав.	-	Хамгаалалтын хашлага- 2,500,000.00 Тэмдэг, тэмдэглэгээ – 50,000.00	Түр хашааны дүн – 40 909 090.00 ХАБЭА-н тэмдэг – 684 230.00
20	Төслийн талбайн газар шорооны ажил, бетон зуурмагийн машинууд гэрээгээр ажил гүйцэтгэсэн. Иймд бид жолооч нарт замын хөдөлгөөний сургалт явуулах шаардлагагүй харин гэрээтдээ мөрдөж ажиллах зүйлсийг гэрээнд нь тусган ажиллалаа. Төслийн талбайд мөрдөх хурдыг 5км/цаг байхаар журамласан.	-	Сургалт-400,000.00	400 000.00
21	Хог хаягдлын тайланд тусгав.	Хог хаягдлын тайлант тодорхой тусгасан.	Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгасан.	
22	Тайлант онд Эрүүл ахуй, БОМТ-ий тухай сургалтуудыг 3 удаа явуулж ажиллалаа. Мөн дотоод журамдаа ажилчдын сахилга бат, согтууруулах ундаа хэрэглэх, ойр орчмын оршин суугчидтай асуудал зөрчил үүсгэх зэрэг асуудлуудын талаар тодорхой зааж, мөрдүүлэх ажлыг үйл ажиллагааны туршид зохион байгуулж ажиллав.	-	Энэ төлөвлөгөөний 7-р хэсэгт заагдсан төсвийн төсвийн хүрээнд	-
Нийт			2,950,000.00	41 993 320.00
7. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний биелэлт				
23	ТУН нь “Баянхошуу дэд төвүүдийн БОМТ-г боловсруулан, БОАЖЯ-аар батлуулан ажилласан байна. Мөн ТУН-ээс тавсан шаардлагын дагуу БО-ны мэргэжилтэнг гэрээгээр ажлуулан, батлагдсан БОМТ-нөөс өөрийн хийж гүйцэтгэх төлөвлөгөөг ялган авч, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан.	-	Үйл ажиллагааны зардалд багтсан	-

**2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН
БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ” ТӨСӨЛ**

24	ТУН-ээс тавсан шаардлагын дагуу БОМТ-г хэрэгжүүлэх БО-ны мэргэжилтэнг гэрээгээр авч ажиллуулсан. БО-ны мэргэжилтэн нь БОМТ-нд тусгагдсан ажлуудыг компанитай хамтран хэрэгжүүлэх, мэргэжлийн заавар зөвлөмжөөр хангах, мэдээлэл солилцох, төслийн захиалагчдыг шаардлагатай тайлан мэдээгээр хангах, БОМТ-ний биелэлтийн тайланг боловсруулан ТУН-д хүргүүлэх зэрэг ажлуудыг гүйцэтгүүлэхээр гэрээлсэн. (Гэрээг хавсралт хэсэгт хавсаргав)	-	Барилгын ажлын төсөвт өртөгт багтсан. Б	1 000 000.00
25	Төслийн талбайд ажиллаж буй инженерүүдэд батлагдсан БОМТ-нд тусгагдсан ажлуудыг танилцуулгыг хийж, хамтран ажиллах ажлыг зохион байгуулж ажилласан.	-	Сургалт-300,000.00	РРТ хэлбэрээр танилцуулсан.
Нийт			300,000.00	1 000 000.00
Нийт төсөв			4,596,750.00	42 345 347.5


4.1.1 Зорилтот бүлгийн 126 айлын орон сууц төслийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын дэлгэрэнгүй тайлан

Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.

1. Төлөвлөгөөнд тусгагдсан тоо хэмжээ болох 0.06га талбайд барилга угсралтын ажил хийгдэж суурийн эргэн булалтын ажил, гадна барилга угсралтын ажил хийгдэж дууссан. Дотоод заслын 90%-тай үргэлжилж байна. Тайлант оны 12 сард комисс ажиллуулахаар төлөвлөн ажиллаж байна. Барилга угсралтын ажил дууссаны дараа орчны тохижилт, ногоон байгууламжийн ажлыг захиалагч талаас тавьсан шаардлага, тоо хэмжээ болон МУ-д мөрдөгдөж буй стандарт нормын дагуу хийж гүйцэтгэх болно.

Зураг-4.1. Орон сууцны барилгын гүйцэтгэл.





2. Төслөөс үүсэх газар шорооны ажлаас гарах хаягдал шороог төслийн хашааны гадна талд түр овоолго үүсгэн хадгалсан. Төслийн барилгын ажил дууссаны дараа орчны тохижилт болон авто замын тэгшилгээнд ашиглах ба илүү гарсан шороог зөвшөөрөлтэй цэгт зайлуулах ажлыг зохион байгуулж ажиллах болно. Барилгын материалын хаягдал, ахуйн хог хаягдлыг зайлуулж ажиллах гэрээг 2021 онд Сонгино хайрхан дүүргийн тохижилт цэвэрлэгээ үйлчилгээний ОНӨААТҮГ газартай байгуулж ажилласан ба тайлант 2022 онд сунгалтыг хийж ажиллалаа. Хаягдал шороог талбайн тэгшилгээнд

ашигласны дараа зайлуулах арга хэмжээг авч, ТУН-д тайлагнаж ажиллах болно.

3. Барилгын суурийн ажлын газар шорооны ажлаас гарсан хаягдал шороог барилгын үйл ажиллагаа явагдаж буй талбайн гадна талд явган хүний гарц, автомашины хөдөлгөөнд саад учруулахгүйгээр овоолго үүсгэн түр хадгалж ажилласан. Хаягдал овоолгыг зайлуулсаны дараа ойр орчмыг техникээр тэгшилж, цэвэрлэгээг хийж, нөхөн сэргээж ажиллах болно.

Зураг-4.2. Хаягдал шорооны овоолго үүсгэж ажилласан байдал.



Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.

4. 2021 онд цаг уурын нөхцөл байдалд тулгуурлан талбайн усалгааг 2021.06.02-2021.09.15 хугацаанд нийт **14 удаа 3,1м³ усаар** усалгаа хийх ажлыг зохион байгуулж ажиллав. Төслийн хэмжээнд боловсон 00 болон талбайн усалгаанд ашиглах усыг зөөврөөр гэрээгээр хангаж ажилласан. Гэрээнд **2.5тн усыг 29240төг** байхаар гэрээнд тусгасан. Тайлант 2022 онд барилгын материалын зөөвөрлөлт өмнөх онтой харьцуулахад харьцангуй бага, хур бороо ихтэй жил байсан тул талбайн усалгаа хийгдээгүй. (Зөөврийн усны гэрээг хавсралт хэсэгт хавсаргав).

Зураг-4.3. Усалгаа хийж буй байдал.



Хүснэгт-4.1. Талбайн усалгааны бүртгэл, мэдээ

Усалгааны мэдээ

"Монкон констракшн" ХХК						
Огноо	Усны эх үүсвэр	Усалгаа эхэлсэн цаг	Усалгаа дууссан цаг	Усалгаанд ашигласан усны хэмжээ /л/	Усалгаа хийсэн хүний нэр	Хянасан хүний нэр
2021.06.4	Заввар	10:30	11:00	200л	Тан. Эрдэнэ	
2021.06.5	+	14:30	14:50	200л	Тан. Эрдэнэ	
2021.06.8	—	9:10	9:40	300л	Тан. Эрдэнэ	
2021.06.10	—	11:30	11:45	200л	Монгол	
11	—	16:10	16:40	200л	Монгол	
18	—	10:00	10:20	300л	Монгол	
25	—	16:10	16:30	200л	Хонгорлоо	
28	—	11:40	12:10	200л	Хонгорлоо	
2021.07.04	—	14:00	14:10	150л	Хонгорлоо	
20	—	11:00	11:00	300л	Хонгорлоо	
26	—	13:00	13:20	300л	Хонгорлоо	
28	—	10:10	10:20	500л	Хонгорлоо	
2021.08.02	—	16:00	16:30	200л	Ойрхуйр	
2021.08.13	—	10:10	10:25	150л	Ойрхуйр	

Хүснэгт-4.2. Талбайн усалгааны мэдээ нэгтгэл.

Д/д	Ус ашиглалт	Сараар					Нийт
		5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	
1	Талбайн усалгаа /л/	-	1800	950	350	-	3100

- ✓ Барилгын ажлын талбайн журам, гамшигаас хамгаалах төлөвлөгөөнд заасаны дагуу онц аюултай байгалийн үзэгдэл болох газар хөдлөлт, салхи, шороон шуурга, бороотой үед гадна орчинд гүйцэтгэж буй барилгын ажлыг түр зогсоож ажилласан.
- ✓ Барилгын сууриас гарсан хаягдал чулуулгийн овоолгыг 1,5м-ээс өндөргүй түр овоолго байгуулан хадгалах ажлыг зохион байгуулж ажилласан. Тайлант хугацаанд хаягдал шороог зайлуулах ажил хийгдээгүй болно.

5. Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн техникийн байдал, хэрэглээний стандартын үзүүлэлтийг хангуулах, автотээврийн хэрэгслээс хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг үр дагаврыг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг, оношлогоог явуулдаг. Техникийн хяналтын үзлэг, оношлогоо хийх тусгай зөвшөөрөл бүхий оношлогооны төв нь Автотээврийн тухай хуулийн 17.1-д заасны дагуу техникийн хяналтын үзлэг, оношлогоо хийж, зохих стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгсэлд замын хөдөлгөөнд оролцох эрхийн гэрчилгээ олгодог. Уг гэрчилгээг авсан техникүүдийг барилгын талбайд ажиллуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Мөн ОХШХ-т агаарын хяналт шинжилгээг мэргэжлийн байгууллага болох БОХЗТЛабораториор 6 болон 8 сард хийлгүүлж ажилласан. Уг шинжилгээний дүнгээс харахад хүхэрлэг хий, азотын давхар исэлийн хэмжээ ЗДХ-нээс хэтрээгүй үзүүлэлттэй байна. /2021, 2022 оны шинжилгээний дүнг ОХШХ-өөс харах/

***Зураг-4.4. Төслийн талбайд ажилласан техникүүдийн
оншилгооны гэрчилгээнүүдийг хавсаргасан байдал.***



6. Барилгын ажлын талбайн журмын 6.1 заасны дагуу талбайн өдөр тутмын цэвэрлэгээг ажил тарахаас **30 минутын** өмнө талбайн инженер болон ХАБЭА-н инженер хариуцан тогтмол хийлгүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. (Хог хаягдлын тайланд тодорхой тусгав)

Физик орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.

7. Барилга угсралтын ажил 1 ээлжээр буюу 09:00-18:00 цагийн хооронд явагдсан. Төслийн талбайд өдрөөр зам талбайн бетон зуурмагийн машин, бусад туслан гүйцэтгэгч нарын техникүүд болон үйлчилгээний зөвшөөрөгдсөн машинууд нэвтрэх эрхтэй байдаг. Тайлант онд төслийн талбайд эвдэрсэн, гэмтэлтэй техник ажиллаагүй. Уг тээврийн хэрэгслийн жолооч нарт ажил гүйцэтгэх хугацаанд зөвхөн шаардлагатай тохиолдолд дуут дохио ашиглах талаар зааварчилгаа өгч ажиллалаа. Төслийн талбайд дуут дохио ашиглахыг хориглосон тэмдэг

тэмдэглэгээг барилгын ажил явагдаж буй хашааны хаалганы үүдэнд байршуулан ажилласан.

Төслийн хугацаанд дуу чимээний хэмжилтийг 6 болон 8 саруудад 2 удаа хийлгүүлж ажиллав.

Зураг-4.5.Төслийн талбайд дуут дохио ашиглахыг хориглох тэмдэг байршуулан ажиллав.



8. 2021.06.10-ны өдөр хог хаягдлын гэрээг Сонгино хайрхан дүүргийн тохижилт цэвэрлэгээ үйлчилгээний ОНӨААТҮГазартай байгуулж ажилласан. Тайлант онд 2022.06.15-ны өдөр тус гэрээг сунгаж ажиллав. /Гэрээг хавсралт хэсэгт хавсаргав.

Хог хаягдал ба түүний менежмент гэдэг нь аливаа хог хаягдлыг **ялгах – цуглуулах – зайлуулах – цэвэрлэх - халдваргүйжүүлэх** цогц арга хэмжээг хэлдэг. Иймд бид төслөөс гарч буй хог хаягдлын ангилан ялгах цэгийг байгуулж, хашаажуулах, тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хог хаягдлыг түр цуглуулах арга хэмжээг авч ажиллаж байна. Барилгын үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлыг (мод, төмөр, хуванцар сав) түр цуглуулах цэгт хадгалан ажиллаж байна. Төслөөс гарч буй модны хаягдлыг нийгмийн хариуцлагын хүрээнд хорооны эмзэг бүлгийн айлуудад (түлшний зориулалтаар) өгөх ажлыг зохион байгуулж ажилласан. Төмрийн хаягдлын хэмжээ бага тул түр цуглуулах цэгт хадгалагдаж байна. Ахуйн хатуу хог хаягдлыг ОХӨААТҮГазартай байгуулсан гэрээний дагуу зайлуулах арга хэмжээг авч ажиллаж байна. Төслийн үйл ажиллагаанаас гарч буй шингэн хог хаягдлыг төвийн шуамд хийлүүлэн ажиллаж байна. Шаардлагатай цэгүүдэд хогийн савнуудыг хангалттай байршуулах ажлыг зохион байгуулж ажилласан.

Гадаргын ба газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.

9. Манай компани нь БО-ны журмыг дотооддоо боловсруулан батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг. Уг журманд асгаралт, түүнээс урьдчилан сэргийлэх, бохирдол үүссэн тохиолдолд авах хариу арга хэмжээ, хог хаягдлын хяналтын тухай тодорхой тусгасан байдаг. Барилга баригдаж буй төслийн талбайд гэрээгээр газар шорооны ажлын үед эксковатор, бетон цутгалтын үед бетон зуурмагийн машинууд болон барилгын материал буулгаж буй машинууд тодорхой хугацаанд нэвтрэн, ажил үүргийг гүйцэтгэн ажилласан. Төслөөс 50м-ын зайд “МТ” ШТС үйл ажиллагаа явуулдаг тул төслийн талбайд түлш цэцэглэх болон ШТМ-ын асгаралт үүссэн тохиолдолд бүртгэгдээгүй. Хэрэв үүссэн тохиолдолд журмын хавсралт-2-ын дагуу бүртгэлжүүлж, хариу арга хэмжээ авч ажилладаг.

Зураг-4.6. БО-ны журам болон журмын хавсралт-2.



Хавсралт № 2								
Асгаралтын хяналтын бүртгэл								
Хаана:								
Илрэлт			Шийдвэрлэлт				Зөвшөөрсөн	
Огноо	Асгаралтын төрөл	Хэмжээ	Огноо	Шийдвэрлэх хэмжээ	Шийдвэрлэх арга зам	Хадгалах хэмжээ	Хариуцагч	Хянагч

10. Унд ахуй, талбайн усалгаа, ариун цэврийн өрөө, боловсон 00-д ашиглах усыг гэрээгээр зөөврөөр ашиглаж байна. Зөөврийн уснаас дээж авч мэргэжлийн байгууллага болох БОХЗТЛабораториар шинжлүүлэн ажилласан. Шинжилгээний дүнгээс харахад ЗДХ-нээс хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна. /Шинжилгээний дүнг ОХШХ-өөс харах/

11. Төслөөс үүсэх шингэн хог хаягдлыг гэрээгээр төвийн шугамд холбуулан зайлуулах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Боловсон ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийг (хлорамин болон жавелин) өдөр бүр хийлгүүлэн ажиллаж байна. (Бохир зайлуулах гэрээг хавсралт хэсэгт хавсаргав.)

Зураг-4.7. Боловсон ариун цэврийн өрөөнд цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийлгүүлж буй байдал.



Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт:

12. Тайлант онд барилгын сууриас гарсан хаягдал шороог зайлуулах ажил хийгдээгүй.
13. Төслийн талбайд шимт хөрс байхгүй. Тохижилт, ногоон байгууламжийн ажлыг хийхэд гаднаас хөрс авч хийнэ.
14. Төслийн талбайгаас 50м зайд “МТ-ШТС” байрлах тул төслийн талбайд техникүүд түлш цэнэглэх асуудал байхгүй. Харин төслийн талбайд нэвтэрч буй техникүүдэд талбайн журмын 5.1 заасны дагуу тойрох үзлэг хийж, шаардлага хангасан техникүүдийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа. Үйл ажиллагааны туршид хөрсөнд ШТМ асгарсан тохиолдол бүртгэгдээгүй.
15. Хог хаягдлын менежментийн дагуу хог хаягдлын ангилан ялгах түр цэгийг байгуулж, хашаажуулж, тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллав. /Хог хаягдлын тайланд тодорхой тусгав. Хог хаягдлын тайланг харах/


Нийгэм, олон нийтэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт:

16. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт хэсгийн 4-т тодорхой тайлагнасан байгаа.
17. Барилга угсралтын ажил 1 ээлжээр буюу 09:00-18:00 цагийн хооронд явагдсан. Төслийн талбайд өдрөөр бетон зуурмагийн машин, бусад туслан гүйцэтгэгч нарын техникүүд болон үйлчилгээний зөвшөөрөгдсөн машинууд нэвтрэх эрхтэй тул уг тээврийн хэрэгслийн жолооч нарт ажил гүйцэтгэх хугацаанд зөвхөн шаардлагатай тохиолдолд дуут дохио ашиглах талаар зааварчилгаа өгч ажиллалаа. Төслийн талбайд дуут дохио ашиглахыг хориглосон тэмдэг тэмдэглэгээг барилгын ажил явагдаж буй хашааны хаалганы үүдэнд байршуулан ажилласан.
18. Барилгын сууриас гарч буй хаягдал шороог барилгын үйл ажиллагаа явагдаж буй талбайн гадна талд явган хүний гарц, автомашины хөдөлгөөнд саад учруулахгүйгээр түр овоолго үүсгэн хадгалсан. Ойр орчмын оршин суугчид болон иргэдээс гомдол санал ирээгүй.
19. Барилгын ажил явагдаж буй талбайг өндөр хашаагаар тусгаарлан, хашааны үүд үүд болон эргэн тойронд барилгын ажил явагдаж буйг илтгэх тэмдэг тэмдэглэгээ байршуулан ажилласан. Мөн хашааны хаалганд төслийн танилцуулга болон санал гомдол хүлээж авах холбогдох хүмүүсийн утасны дугаарыг байршуулан ажилласан.

Зураг-4.7. Барилгын ажил явагдаж буй талбайг өндөр хашаагаар тусгаарлсан байдал.



Зураг-4-9. Төслийн танилцуулга болон холбогдох хүмүүсийн утасны дугаар.



20. Төслийн талбайн газар шорооны ажил, бетон зуурмагийн машинууд гэрээгээр ажил гүйцэтгэсэн. Иймд бид жолооч нарт замын хөдөлгөөний сургалт явуулах шаардлагагүй харин гэрээтдээ мөрдөж ажиллах зүйлсийг тусган ажиллалаа. Төслийн талбайд мөрдөх хурдыг 5км/цаг байхаар журамласан.
21. Хог хаягдлын тайланд тусгав.
22. Тайлант онд Эрүүл ахуй, БОМТ-ий тухай сургалтуудыг 3 удаа явуулж ажиллалаа. Мөн дотоод журамдаа ажилчдын сахилга бат, согтууруулах ундаа хэрэглэх, ойр орчмын оршин суугчидтай асуудал зөрчил үүсгэх зэрэг асуудлуудын талаар тодорхой зааж, мөрдүүлэх ажлыг үйл ажиллагааны туршид зохион байгуулж ажиллав.

Зураг-4.10. Ажилчдын эрүүл мэнд, дасгал хөдөлгөөн хийж буй байдал.





Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ:

23. ТУН нь “Баянхошуу дэд төвүүдийн БОМТ-г боловсруулан, БОАЖЯ-аар батлуулан ажилласан байна. Мөн ТУН-ээс тавсан шаардлагын дагуу БО-ны мэргэжилтэнг гэрээгээр ажлуулан, батлагдсан БОМТ-нөөс өөрийн хийж гүйцэтгэх төлөвлөгөөг ялган авч, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан.
24. ТУН-ээс тавсан шаардлагын дагуу БОМТ-г хэрэгжүүлэх БО-ны мэргэжилтэнг гэрээгээр авч ажиллуулсан. БО-ны мэргэжилтэн нь БОМТ-нд тусгагдсан ажлуудыг компанитай хамтран хэрэгжүүлэх, мэргэжлийн заавар зөвлөмжөөр хангах, мэдээлэл солилцох, төслийн захиалагчдыг шаардлагатай тайлан мэдээгээр хангах, БОМТ-ний биелэлтийн тайланг боловсруулан ТУН-д хүргүүлэх зэрэг ажлуудыг гүйцэтгүүлэхээр гэрээлсэн. (Гэрээг хавсралт хэсэгт хавсаргав)
25. Төслийн талбайд ажиллаж буй инженерүүдэд батлагдсан БОМТ-нд тусгагдсан ажлуудыг танилцуулгыг хийж, хамтран ажиллах ажлыг зохион байгуулж ажилласан.

4.2 Салбар шугамын холболт хийх HSSC-C багц

№	Сөрөг нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Ажлын хэмжээ	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/
1. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт				
1	Салбар шугам тавих нүх шуудууг ухах ажилд өртөж эвдэрсэн 0.5 га талбайд талбайд газар шорооны ажил дуусмагц нөхөн дүүргэлт, хэлбэршүүлэх, тэгшилгээний ажлууд хийж, анхны төрх байдалд нь нийцүүлэн орчны тохижилт үүсгэх	Ногоон байгууламж, тохижилтийг барилгын ажил дууссаны дараа хийж гүйцэтгэнэ.	Төлөвлөгөөнд ногоон байгууламжийн ажлын зардалд тусгасан.	Барилгын ажил дуусаагүй тул хийгдээгүй.
2	14,287 м³ хэмжээтэй шороон материалыг шуудууны нөхөн дүүргэлтэд ашиглаж, үлдсэн 4,220 м³ хэмжээтэй хаягдал шороон материалыг Цагаандавааны хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулах зөвшөөрлийг СХД-ийн хот тохижилтын газраас авч, хог хаягдлын гэрээнд тусган оруулж өгнө. - Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын хэмжээ, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж, 7 хоног бүр ТУН-д тайлагнана.	Хаягдал шороог төслийн талбайгаас зөөгдөх ажил хийгдээгүй.	Үйл ажиллагааны зардалд тусгасан.	-
3	- Салбар шугам тавих газар шорооны ажлуудаас бий болох шороон материалын овоолгыг үүсгэхдээ орц, гарц, зам талбайг хааж, хөдөлгөөнд саад учруулахгүйгээр тооцож байрлалыг сонгох - Барилгын ажил явагдаж буй цэгүүдэд талбайн цэвэрлэгээг өдөр тутам хийж, барилгын хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт тогтмол зайлуулж байх - Газар шорооны ажил дуусмагц шороон материалын овоолго байрлаж байсан цэгт талбайн цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх		Нөхөн сэргээлт, тохижилтын ажлын төлөвлөгөөнд багтсан.	-
Нийт төсөв			-	-
2. Агаар орчин хамгаалах чиглэлээр авч хэмжээний биелэлт				
4	- Салбар шугам тавих газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд хуурай өдрүүдэд м² талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх - Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс ачиж буулгах болон газар шорооны ажлыг түр зогсоох - Хүчтэй салхи шуургатай үед хөрсний овоолгоос тоосжилт үүсэхээс сэргийлж усалгаа хийх - Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх	Усалгаанд 3.1 м3 усыг ашигласан байна.	Талбайн усалгаа - 546,750.00 Овоолго бүтээх – 750,000.00	Усалгааны зардал- 36257,6төг Овоолгыг бүтээх ажил хийгдээгүй.
5	- Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникүүдийг сар бүр үзлэгт оруулж, утаа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх - Тээврийн хэрэгсэл болон хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, оношлогоо үйлчилгээг тогтмол, чанартай хийх	Агаарын шинижлэгээг 6, 8 саруудад 2 удаа мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж ажиллав.	ОХШХ-т тусгасан.	-
6	Тээврийн хэрэгслийн утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих аргын стандартын /MNS 5013:2009, MNS5014:2009/ дагуу хянаж зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгах	Тогтмол хийлгүүлж ажиллав.	Үйл ажиллагааны зардалд тусгасан	-
Нийт				

2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ” ТӨСӨЛ

3. Физик орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт				
7	- Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэг, оношлогоо, засварыг сар бүр хийж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гарахыг хориглох - Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх - Дуу чимээний мониторинг хэмжилт хийж хяналт тавих	Дуу чимээний хэмжилтийн дүнг ОХШХ-т үзүүлэв.	ОХШХ-т тусгасан	-
8	- СХД-ийн тохижилт үйлчилгээний газартай хог хаягдлын гэрээ байгуулж, түүнд хаягдал шороон материал, ахуйн ба барилгын хог хаягдлыг зайлуулах цэг ба тээвэрлэх автомашины улсын дугаарыг тодорхой зааж өгөх - Барилгын ажил явагдаж буй цэгүүдэд хогийн хаягдлын цэг тогтоож, зориулалтын хогийн сав байрлуулах - Барилгын түр кэмпэд хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж, тэмдэгжүүлэх	-	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	-
Нийт			-	-
4. Гадаргын ба газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт				
9	- Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх - Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх - Шатах тослох материал асгарсан үед, хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах	-	50,000.00	-
10	- Үйл ажиллагаанд шаардагдах усны эх үүсвэр, хэрэглээг тогтоож, ус ашиглалтын гэрээ байгуулж ажиллах - Ашиглаж буй усны хэмжээ, чанарт хяналт тавьж ажиллах	Хүснэгт-4.3-г харах	Үйл ажиллагааны зардалд тусгасан.	-
11	- Барилгын түр кэмпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх - Барилгын түр кэмпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминт цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх	-	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	-
Нийт			50,000.00	0,0
5. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт				
12	- Хөрсний эвдрэл талхагдал үүсэхээс сэргийлж хүнд даацын машинуудыг тогтсон маршрутаар зорчуулах - Барилгын ажил дуусах үед хөрс суларч доройтон, хөрсний элэгдэл үүссэн газруудад нөхөн сэргээлт хийх	-	Нөхөн сэргээлт, тохижилтын ажлын төлөвлөгөөнд тусгасан.	-
13	- Газар шорооны ажилд өртөж эвдэрсэн ... га талбайд талбайд газар шорооны ажил дуусмагц нөхөн дүүргэлт, нөхөн сэргээлт, тохижилтын ажлууд хийх - Газар шорооны ажлын үед өнгөн хөрсний овоолгыг тусад нь үүсгэж стандартын дагуу хадгалах ба барилгын ажил дуусах үед нөхөн сэргээлтэд ашиглах	-	Нөхөн сэргээлт, тохижилтын ажлын төлөвлөгөөнд тусгасан.	-

2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ” ТӨСӨЛ

14	- Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх - Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асарч алдагдахаас сэргийлэх	-	Үйл ажиллагааны зардалд багтсан.	
15	- Барилгын ба ахуйн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх - Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох - Барилгын түр кэмпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх - Барилгын түр кэмпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминт цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх	-	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	-
Нийт			-	-
6. Нийгэм, олон нийтэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт				
16	- Газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд 1 м² талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх - Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс газар шорооны ажлыг түр зогсоох - Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх	-	Энэхүү төлөвлөгөөний 2-р хэсэгт заагдсан төсвийн хүрээнд	-
17	- Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх - Шаардлагатай тохиодолд дуу чимээ тусгаарлах зөөврийн хана ашиглах - Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх	Физик нөлөөллийн 7-г харах	ОХШХ-т тусган оруулсан	-
18	- Барилгын ажил явагдаж буй цэгүүдийн ойр орчимд явган хүн ба тээврийн хэрэгсэл чөлөөтэй зорчих зам, орц гарцыг бий болгож өгөх - Барилгын материал хураах, хөрсний овоолго үүсгэх цэгийг сонгохдоо оршин суугчдын хөдөлгөөнд саад учруулах буюу орц гарцыг хаахгүй байхаар төлөвлөх	-	Үйл ажиллагааны зардалд багтсан	-
19	Зүсэх, гагнах ажлууд хийгдэх цэгүүдийг тойруулж хамгаалалтын хашлага татах, анхааруулах тэмдэг байршуулах	-	Хамгаалалтын хашлага- 2,500,000.00 Тэмдэг, тэмдэглэгээ – 50,000.00	Түр хашааны дүн – ХАБЭА-н тэмдэг – 684 230.00
20	- Хүнд даацын машины жолооч нарыг замын хөдөлгөөний аюулгүй байдлын давтан сургалтад хамруулах, гэр хорооллын суурьшлын бүс дунд үүсч болзошгүй эрсдэл, осол аваарийн талаар тайлбарлан таниулах - Гэр хороолол дунд тээврийн машины хурдыг хязгаарлах дүрэм мөрдүүлэх	-	Сургалт-400,000.00	400 000.00

**2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА
БАЙГУУЛАМЖ БАРИХ” ТӨСӨЛ**

	Тээврийн жолооч нарт худаг, хүүхдийн сургууль, цэцэрлэг, явган хүний гарц, уулзвар зэрэг осол аваарь гарах эрсдэл бүхий цэгүүд дээр 5 секунд зогсоод хөдлөх дүрэм мөрдүүлэх			
21	Шугам хоолой байрлуулах зорилгоор ухсан нүх шуудууг хамгаалалтын торон хашлагаар хашиж хүрээлэх, анхааруулах тэмдэг байрлуулах	Хог хаягдлын тайлант тодорхой тусгасан.	Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгасан.	
22	Барилгын түр кэмпэд дараах эрүүл ахуйн үндсэн шаардлагууд тавигдана. Үүнд: - Хатуу хог хаягдлын менежмент. Хатуу хог хаягдлыг түр хадгалах зориулалтын цэг бий болгож, хашлага хамгаалалт хийж, тэмдэг тэмдэглэгээ байршуулах, СХД-ийн ТҮК-тэй хог хаягдлыг тээвэрлэх гэрээ байгуулж цугларсан хог хаягдлыг 7 хоногт 2 удаа ачуулж байх - Шингэн хог хаягдлын менежмент. Кэмпээс гарах бохир усыг битүү саванд түр хадгалж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх - Ажилчдын 00. Эрүүл ахуйн шаардлага хангасан 00-той байх, 00-н нүхэнд био-бэлдмэл ашиглаж халдваргүйжүүлэлт хийх, ойр орчмыг нь хлораминт шингэнээр тогтмол ариутгаж цэвэрлэх	-	Энэ төлөвлөгөөний 7-р хэсэгт заагдсан төсвийн төсвийн хүрээнд	-
Нийт			2,950,000.00	
7. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний биелэлт				
23	Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч нь БОАЖЯ-аар батлагдсан энэхүү БОМТ дээр үндэслэн Г-БОМТ-г боловсруулж ТУН-д хянуулж батлуулна.	-	Үйл ажиллагааны зардалд багтсан	-
24	Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллага нь талбайн байгаль орчны ажилтантай байх ба уг ажилтан нь Г-БОМТ-г боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, барилгын ажлын талбарт өдөр тутмын БО-ны хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.	-	Барилгын ажлын төсөвт өртөгт багтсан. Б	1 000 000.00
25	Бүх барилгын ажилчдыг хамруулсан БО-ны сургалт зохион байгуулж, БО-ны чиглэлийн хууль, журмын шаардлага, стандарт, БОМТ-д тусгагдсан бууруулах арга хэмжээг тайлбарлан таниулна.	-	Сургалт-300,000.00	РРТ хэлбэрээр танилцуулсан.
Нийт			300,000 төгрөг	1 000 000.00
Нийт төсөв			3,810,000 төгрөг	42 345 347.5

2022 онд хийгдсэн ажлын зургууд

УДДТөвийн барилга









4.3 BDSC-BKH гэрээний дугаартай Спорт цогцолбор төсөл

Сөрөг нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Төлөвлөгөө /төг/	Биелэлт /төг/
Агаарын чанар			
Төслийн үйл ажиллагаанд ашиглах түүхий эд (элс, хайрга, цемент гэх мэт)-ийг тээвэрлэхэд тэвшнээс тоос тоосонцор дэгдэхээс урьдчилан сэргийлж тэвшийг бүтээх	Урьдчилан сэргийлж тэвшийг бүтээдэг	Дотоод төлөвлөгөөгөөр	-
Нийт тээвэрлэлтийн явцад эвдэрсэн хөрс бүхий газрын гадаргаас агаарт дэгдэх тоос тоосонцрыг бууруулахын тулд төслийн талбайд зорчих нийт тээврийн хэрэгслүүдэд хурдны хязгаар тогтоох зорилгоор трассын дагуу төслийн талбайд тэмдэг, тэмдэглэгээ байршуулах	Хурдны хязгаар тогтоох зорилгоор трассын дагуу төслийн талбайд тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан	Дотоод төлөвлөгөөгөөр	-
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, суларсан хөрс бүхий задгай талбайгаас үүсэх тоосжилтыг бууруулахын тулд төслийн талбайг чийгшүүлж услах	Тоосжилтыг бууруулахын тулд төслийн талбайг чийгшүүлж усладаг	1 260 000	1 260 000
Төслийн үйл ажиллагаанд ашиглах нийт тээврийн хэрэгслүүдийг үзлэг оношилгоонд хамруулах, оношилгоонд тэнцсэн буюу шаардлага хангасан машин, техник ашиглах, тэдгээрийн агаарын бохирдлын төлбөр төлөх	Төслийн талбайд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийг үзлэг оношилгоонд оруулдаг	110 000	110 000
Хөдөлмөрийн аюулгүй байдал болон бусад эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс цаг агаарын аюултай болон онц аюултай үед барилгын ажлыг зогсоох (цаг агаарын урьдчилсан мэдээ болон хуанли бүртгэж ажиллах)	Цаг агаарын урьдчилсан мэдээ болон хуанли бүртгэж ажилладаг	Дотоод төлөвлөгөөгөөр	-
Барилга байгууламжийн ажлын үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах, тогтсон нэг замаар зорчуулах хуваарь гаргах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан	Дотоод төлөвлөгөөгөөр	-
Ашиглаж буй машин механизм, техник хэрэгслээс гарах химийн хорт бодис бүхий хий, утааг багасгахын тулд барилгын ажилд ашиглаагүй үед унтраах	Барилгын ажил явагдаагүй үед машин механикмуудыг унтраадаг	-	-
Дуу шуугианы түвшнийг бууруулахын тулд барилгын ажил гүйцэтгэхэд дуу чимээ бага гаргадаг машин тоног төхөөрөмжийг сонгох, машин механизм, тоног	Машин механизм, тоног төхөөрөмжид тогтмол засвар үйлчилгээ хийдэг	Дотоод төлөвлөгөөгөөр	-

2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ” ТӨСӨЛ

төхөөрөмжид тогтмол засвар үйлчилгээ хийх, тэдгээрт дуу намсгагч хэрэглэх, дуу чимээ ялгаруулалт багатай технологийн ажилбарыг ашиглах			
Дуу чимээ ихтэй ажлыг өглөө 7-оос орой 22 цагаас хойш хүртэл илүү цагаар ажиллах бол ойр орчмын иргэдэд ажил хийгдэхээс өмнө мэдэгдэх	Барилгын ажлыг өглөө 7-оос орой 22 цагийн хооронд явуулдаг	Дотоод төлөвлөгөөгөөр	-
Шуугианы түвшнийг зохицуулж хянаж байх, чимээ ихтэй тоног төхөөрөмж ашиглахгүй байх	Чимээ ихтэй тоног төхөөрөмж ашиглаагүй	Дотоод төлөвлөгөөгөөр	-
Усан орчин			
Барилгын усны хэрэгцээг дэд төвийн гадна байгаа, зөвшөөрөгдсөн эх үүсвэрүүдээс усны машинаар ажлын талбайд хүргэх, ажлын талбарт том саванд хадгалсан усаар хангах	Ус хуримтлуулах саванд усаа хадгалж усаар хангадаг		-
Хөрс, ургамал, газрын гадарга			
Авто замын бүх трассын дагуу хийгдэх ажлын өнгөн хөрсний үржил шимт хэсгийг хадгалж техникийн нөхөн сэргээлт хийх	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн хэсэгт орсон	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн хэсэгт орсон.	
Хэрэв шугам хоолой тавихдаа явган хүний зам болон авто зам хөндсөн тохиолдолд буцаан өмнөх байдалд оруулах, дагтаршуулах	Барилгын ажил бүрэн дуусаагүй байгаа учир явган хүний зам, авто замыг өмнөх байдалд оруулаагүй байгаа	Үйл ажиллагааны туршид	-
Тоосжилтоос үүдэн ургамлын амьдрах чадвар буурч, фотосинтезийн үйл ажиллагаа явагдахгүй болох магадлалтай тул тоосжилт үүсэх эх үүсвэрүүдийг услах, тоосжилтийг бууруулах	Тоосжилтыг бууруулахын тулд төслийн талбайг чийгшүүлж усладаг	Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэсэгт орсон.	
Хог хаягдал салхиар дамжиж тархах болон хөрсөнд нэвчих байдлаар ургамал, хөрс, гүний усыг бохирдуулах нөхцөл болох тул нэгдсэн нэг цэгт төвлөрүүлж, зохих стандарт шаардлагын дагуу устгана.	Хог хаягдлыг нэгдсэн цэгт төвлөрүүлдэг	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө хэсэгт орсон.	-
Машин, механизмын засвар үйлчилгээг зөвхөн зориулалтын засварын байр, талбайд хийж гүйцэтгэх	Машин, механизмын засвар үйлчилгээг зөвхөн зориулалтын засварын байр, талбайд хийж гүйцэтгэдэг		-

2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ” ТӨСӨЛ

Барилгын ажлын талбай дахь хатуу хог хаягдлыг цуглуулж, зохих журмын дагуу зайлуулж байх	Дүүргийн ТҮК-тай хог хаягдлын гэрээ байгуулж ажиллаж байгаа		-
Нийт			1 370 000

Зураг 1 Автомашины техникийн хяналт үзлэгийн мэдээлэл

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ Улсын дугаар: 2088YP Загвар: Shandong Lugong LG953 Үйлдвэрлэсэн он: 2021 Залгах COVID-19 зөвшөөрөл ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ Үзлэгт орсон огноо: 2022/05/17 Үзлэгт дахин орох огноо: 2023/01/01 Тэнцсэн эсэх: Тийм	ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ Улсын дугаар: 2566YБЗ Загвар: Zoomlion QY25H Үйлдвэрлэсэн он: 2013 Залгах COVID-19 зөвшөөрөл ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ Үзлэгт орсон огноо: 2022/07/18 Үзлэгт дахин орох огноо: 2023/07/18 Тэнцсэн эсэх: Тийм
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ Улсын дугаар: 2795YБӨ Загвар: HINO Ranger U-GD3HJAA Үйлдвэрлэсэн он: 1994 Залгах COVID-19 зөвшөөрөл ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ Үзлэгт орсон огноо: 2022/02/17 Үзлэгт дахин орох огноо: 2023/02/17 Тэнцсэн эсэх: Тийм	ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ Улсын дугаар: 6320YHH Загвар: Sinotruck ZZ1257N4641W Үйлдвэрлэсэн он: 2014 Залгах COVID-19 зөвшөөрөл ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ Үзлэгт орсон огноо: 2022/07/25 Үзлэгт дахин орох огноо: 2023/07/25 Тэнцсэн эсэх: Тийм
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ Улсын дугаар: 0745YБЕ Загвар: KIA Bongo Frontier Үйлдвэрлэсэн он: 2002 Залгах COVID-19 зөвшөөрөл ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ Үзлэгт орсон огноо: 2022/02/17 Үзлэгт дахин орох огноо: 2023/02/17 Тэнцсэн эсэх: Тийм	ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ Улсын дугаар: 0745YБЕ Загвар: KIA Bongo Frontier Үйлдвэрлэсэн он: 2002 Залгах COVID-19 зөвшөөрөл ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ Үзлэгт орсон огноо: 2022/02/17 Үзлэгт дахин орох огноо: 2023/02/17 Тэнцсэн эсэх: Тийм



5 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ

5.1 Нөхөн сэргээлтийн ажил хийх талбайн хэмжээ

Баянхошуу- Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төслийн барилгын ажлын үед 9.7 мян.м.кв-д талбайд газар шорооны ажил хийгдэхээр 2021 оны төлөвлөгөөнд тусгасан боловч үүнээс 2 барилга байгууламжын барилгын ажил эхлээгүй. Үлдсэн 4 барилга байгууламж нь 3.5 мян мкв талбайд барилгын ажил гүйцэтгэж байна. Энэ жил барилгын ажил дуусаагүй 15-60% гүйцэтгэлтэй явж байгаа болохоор нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй.. Тухайн ажил хийгдэж дууссаны дараа барилгын талбайн ойролцоо эвдэрсэн болон талхагдсан газарт нөхөн сэргээлтийн ажил хийнэ.

Хүснэгт 5-1. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

No	Багц №	Нийгмийн байгууламжийн нэр	Тайлбар, тодруулга	Нөхөн сэргээлт хийгдэх эсэх
1	ASKG-BKH	240 хүүхдийн цэцэрлэг	1168 м.кв тоглоомын талбай бүхий 2316 м.кв цэцэрлэгийн барилга	Тайлант онд барилгын ажил дуусаагүй тул нөхөн сэргээлт, ногоон байгууламж хийгдэхгүй.
2	DDCD-BKH	"Олон нийтийн хөгжлийн төв"	Барилга нь 1121 м.кв талбай бүхий барилга	
3	BDSC-BKH	Спорт цогцолбор	18424 м.кв гадна зам талбай бүхий 5761 м.кв талбайтай барилга	Барилгын ажил эхлээгүй нөхөн сэргээлт хийгдэхгүй
4	FRS-BKH	Гал унтраах, аврах 29-р ангийн барилга	Барилгажих талбай 3120м2	
6	DDPK-BKH	Баянхошуу цэцэрлэгт хүрээлэн	Нийт 2 га газарт 8336 м.кв бүхий ногоон байгууламж, авто машины ил зогсоол, спорт талбай, хүүхдийн тоглоомын талбай	Тайлант онд барилгын ажил дуусаагүй тул нөхөн сэргээлт, ногоон байгууламж хийгдэхгүй..

2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ” ТӨСӨЛ

6	SHS	Зорилтот бүлгийн орон сууц	Тус бүр нь 63 айлтай, 9 давхар, орон сууцны 2 барилга	Тайлант онд барилгын ажил дуусаагүй тул нөхөн сэргээлт, ногоон байгууламж хийгдэхгүй.
	HSSC-C	Салбар шугамын холболтын ажлууд		Тайлант онд барилгын ажил дуусаагүй тул нөхөн сэргээлт, ногоон байгууламж хийгдэхгүй.
	/BKHS/	Баянхошуу талбай		Тайлант онд барилгын ажил дуусаагүй тул нөхөн сэргээлт, ногоон байгууламж хийгдэхгүй.

6 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ

Хүснэгт 6-1. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ, биелэлт

Гэрээт багцууд	Төлөвлөгөө	Хэрэгжилт
ASKG гэрээний дугаартай 240 хүүхдийн цэцэрлэг	Төслийн хүрээнд нийгмийн барилга байгууламж баригдах талбай, тэдгээрийн ойр орчимд түүх, соёлын өв, дурсгалт газрууд байхгүй болох нь төсөл хэрэгжих талбайд хийгдсэн судалгааны явцад тогтоогдсон. Иймд энэхүү төсөлд түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө боловсруулан ажиллах шаардлага байхгүй болно.	Тус төслийн 2022 оны барилгын ажлын үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илрээгүй болно.
DDCD-BKH гэрээний дугаартай олон нийтийн хөгжлийн төв		
SHS гэрээний дугаартай зорилтот бүлгийн орон сууц төслийн		
BDSC-BKH гэрээний дугаартай Спорт цогцолбор		
FSBKH гэрээний дугаартай Гал түмэр унтраах, аврах 29-р ангийн барилга		

2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ” ТӨСӨЛ

Гэрээт багцууд	Төлөвлөгөө	Хэрэгжилт
DDPK-BKHгэрээний дугаартай Баянхошуу цэцэрлэгт хүрээлэн		
HSSC-C гэрээний дугаартай Салбар шугамын холболтын ажлууд		
DDPK-BKH гэрээний дугаартай Баянхошуу цэцэрлэгт хүрээлэн		2022оны ажлын үед Булш олдсон бөгөөд хамгаалалтанд авч судалгаа шинжилгээ хийлгэсэн.

Тус төслийн барилгын ажлын үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллах шаардлагатай. Дагуу **DDPK-BKH гэрээний дугаартай Баянхошуу цэцэрлэгт хүрээлэнгийн талбайгаас олсон Булшыг хамгаалалтанд авсан юм.**

7 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

БОННУ-ний судалгааны баг “Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих” төслийн талбайд ажиллаж, газар ашиглалтын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлсон судалгааг хийсэн юм. Дээрх хүснэгтэд үзүүлсэн газар эзэмшилтийн судалгаанаас харахад хүүхдийн цэцэрлэг, Олон нийтийн хөгжлийн төв, Спорт цогцолбор, Гал унтраах анги, зорилтот бүлгийн орон сууц, Баянхошуу цэцэрлэгт хүрээлэн зэрэг байгууламжуудыг төрийн өмчит аж ахуйн нэгжид олгогдсон газар дээр барих тул газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх шаардлагагүй төсөл болно.

Хүснэгт 7-1. Барилга баригдах газрын эзэмшлийн нөхцөл байдал

No.	Package Number	Нийгмийн байгууламжийн нэр	Тайлбар, тодруулга	Байршил	Газар эзэмшигчийн нэр	Олгогдсон газрын хэмжээ	Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт хийгдэх эсэх
1	ASKG-BKH	240 хүүхдийн цэцэрлэг	1168 м.кв тоглоомын талбай бүхий 2316 м.кв цэцэрлэгийн барилга	СХД-ийн 40-р хороо	НЗД-ын 2020.01.27-ний өдрийн А/101 тоот захирамжаар цэцэрлэгийн газрыг нийслэл-н боловсролын газар руу, ОНХТ-н газрыг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар руу шилжүүлсэн.	8401м2	Нүүлгэн шилжүүлэлт хийгдэхгүй.
2	DDCD-BKH	"Олон нийтийн хөгжлийн төв"	Барилга нь 1121 м.кв талбай бүхий барилга			6702.3м2	
3	BDSC-BKH	Спорт цогцолбор	18424 м.кв гадна зам талбай бүхий 5761 м.кв талбайтай барилга	СХД-ийн 40-р хороо	ОБЕГ-ын Гал унтраах, аврах 29-р анги	57131м2	Нүүлгэн шилжүүлэлт хийгдэхгүй.
4	FRS-BKH	Гал унтраах, аврах 29-р ангийн барилга	Барилгажих талбай 3120м2				Барилгын ажил эхлээгүй нүүлгэн шилжүүлэлт хийгдэхгүй

**2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА
БАЙГУУЛАМЖ БАРИХ” ТӨСӨЛ**

6	DDPK-BKH	Баянхошуу цэцэрлэгт хүрээлэн	Нийт 2 га газарт 8336 м.кв бүхий ногоон байгууламж, авто машины ил зогсоол, спорт талбай, хүүхдийн тоглоомын талбай	СХД-ийн 24,25-р хороод	СХД-н орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газар	20,000м2	Нүүлгэн шилжүүлэлт хийгдэхгүй.
6	SHS	Зорилтот бүлгийн орон сууц	Тус бүр нь 63 айлтай, 9 давхар, орон сууцны 2 барилга	СХД-ийн 6-р хороо	НОСК	5,000м2	Нүүлгэн шилжүүлэлт хийгдэхгүй.

7.1.1 HSSC-C гэрээний дугаартай салбар шугам барих төсөл

Баянхошуу дэд төв дэх нийгмийн барилга байгууламжуудын усан хангамж, ариутгах татуурга болон дулааны шугамын угсралтын ажлын хүрээнд нийт 2 айлын хашаа бүтэн, 1 айлын хашаа тал багтсан. 2022 онд нүүлгэн шилжүүлэлтийн ажил хийгдэж дууссан.

Нүүлгэн шилжүүлсэн айлын суурийг цэвэрлэн хаяж буй байдал



Зураг 1. Нүүлгэн шилжүүлсэн 2 айлын нүхэн жорлонг ариутган дарж буй байдал



8 ОСОЛ ЭРСДЭЛ, ХИМИЙН БОДИСЫН МЕНЕЖМЕНТ, БИЕЛЭЛТ

8.1 SHS гэрээний дугаартай зорилтот бүлгийн орон сууц төслийн осол эрсдэл, химийн бодисын менежмент, биелэлт

Байгалийн аюул, гамшигт нөхцөл байдал.

Үерийн эрсдэл:

1. “Монкон констракшн” нь аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос хүн болон хүрээлэн буй орчныг урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох, гамшигт нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, ажлыг холбогдох хууль, эрхзүйн баримт бичгийн дагуу зохион байгуулж гүйцэтгэх үед мөрдөн ажиллах удирдлагын үндсэн баримт бичиг болох гамшгаас хамгаалах төлөвлөгөөг батлуулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ашиглаж байна. Уг төлөвлөгөөний 2-р хэсэгт үерийн усны аюулын төлөвлөгөөг тусгасан байна. Төлөвлөгөөнд үерийн усны аюулд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор барилгын түр оффис, брилгын материалын агуулахыг төслийн хашаан дотор өндөрлөг хэсэгт байршуулан ажиллав.

Зураг-8.1. Түр оффис, агуулах.



2. Төслийн дулаан, цэвэр, бохирын шугамын ажлыг хур бороогүй үед буюу цаг уурын нөхцөл байдалд тулгуурлан хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулж ажилласан.
3. Гамшигаас хамгаалах төлөвлөгөөг дотооддоо боловсруулан, гүйцэтгэх захирлаар батлуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

. Гамшигаас хамгаалах төлөвлөгөө.

**“MONCON CONSTRUCTION” LLC
FOR ALL PROJECTS**

Батлав: “МОНКОН КОНСТРАКШН” ХХК-ий
ГҮЙЦЭГТЭХ ЗАХИРАЛ

Г. БАТБАЯР

“МОНКОН КОНСТРАКШН” ХХК-ий
ГЭМШИГЭЭС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хамрах хүрээ: Нийт тусгай болон айва, хамгийн хүрээнд
Дугаар №:

УЛААНБААТАР ХОТ 2019 ОН

MONCON
“MONCON CONSTRUCTION” LLC
FOR ALL PROJECTS

БАРИМТ БИЧИЙН ХЯНАЛТ / DOCUMENT CONTROL

Баримтын мэдээлэл / Document Information

Мэдээлэл / Information
Баримт бичгийн нэр / Name
Баримт бичгийн огтлоо / Issue Date
Баримт бичгийн хугацаа / Validity
Баримт бичгийн хугацаа / Validity

Баримтын түүх / Document History

Хувилбар / Version	Батлагдсан өдөр / Issue Date	Өөрчлөлт / Changes
1.0	2019.04.28	ХАБЭА-н хамгаалах төлөвлөгөө

Батлагдсан / Document Approvals

Айва тусгай / Role	Нэр / Name	Гарын үсэг / Signature	Огноо / Date
ХАБЭА-н хамгаалах дэргэ	Д.Монхбат		
ХАБЭА-н хамгаалах хамгаалах	Ц.Цэндсүрэн		

Газар хөдлөлтийн аюул, эрсдэл

- Гамшигаас хамгаалах төлөвлөгөөнд тусгасаны дагуу газар хөдлөлтийн гамшигийн үед ажиллах төлөвлөгөө, хөлдөлт, цохир хүйтрэл, цасан болон шороон шуурга, үер усны аюул зэрэг байгалийн аюулт үзэгдэлийн үед ажиллах хариу арга хэмжээний тухай сургалтыг төслийн талбайд ажиллаж буй нийт ажилчид, туслан гүйцэтгэгч нарыг хамруулан зохион байгуулж байна. ХАБЭА-н сургалтууд төслийн талбайд явагдсан тул хэрэгжүүлэх ажлын зардал гараагүй.
- Байгалийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед түр цугларах цэг буюу “Master Point”-ийг төслийн хашааны гадна талд байршуулан, нийт ажилчдад сургалтаар орсон болно. (Зардал нь Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлтийн ХАБЭА-н тэмдэг тэмдэглэгээний зардалд орсон болно.)

Зураг-8.2. Цугларах цэг.




- Улаанбаатар хотын хэмжээнд 95 орчим мянган барилга байгаагаас 25 орчим мянган нь нийтийн эзэмшлийн зориулалттай бөгөөд 3 мянга орчим нь болзошгүй газар хөдлөлтийн 6-8 баллын үед нурах эрсдэл бүхий барилга

байгууламж байна. Иймд бид барилгын ажлыг гүйцэтгэхдээ Захиалагч талаас тавьсан шаардлагын дагуу барилгын материалын чанар, орцод нийцсэн материалаар барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэж байна. Бидний төлөвлөгөөгөөр тайлант оны 11 сард барилгын ажлыг дуусган комисс ажлуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Гал түймрийн аюул эрсдэл

7. Манай компани нь нийт ажилчдын хөдөлмөрийн аюлгүй байдлыг хангаж ажиллах зорилгоор ХАБЭА-н хэлтсийг байгуулан ажиллаж байна. Хэлтсээс галын аюулгүй байдлын журмыг боловсруулан, нийт ажилчдад сургалт хийх ажлыг тогтмол зохион байгуулж ажилладаг. Журамд заасны дагуу ажилчдын түр оффис, барилгын материалын агуулах болон шинээр баригдаж буй барилгын давхар тус бүрт гал унтраах хэрэгслийг цэнэглэж, байршуулах ажлыг зохион байгуулж ажиллав. Төслийн талбайд нийт 28ш галын хор байршуулан ажилласан. (1 500 000төг зардал төлөвлөгдсөн).

Зураг-8.3. Гал унтраах хэрэгсэл байршуулж ажилласан байдал.





8. Галын аюулгүй байдлын журмын дагуу барилгын ажил гүйцэтгэж буй нийтажилчид болон туслан гүйцэтгэгч компанийн ажилчдад галын аюулгүй байдлын сургалтыг өгч ажиллахаас гадна өдөр тутмын ажил гүйцэтгэлийн хуудсаар галын аюулгүй ажиллагааг хангаж ажиллах заарчилгааг өдөр бүр өгч ажилладаг.
9. “Галын аюулгүй байдлын тухай хууль”-ийн дагуу дотооддоо галын болзошгүй аюул, ослын үед авах арга хэмжээг төлөвлөн “Галын аюулгүй байдлын журам”-ыг боловсруулан, гүйцэтгэх захирлаар батлуулан, мөрдөх ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

Зураг-8.4. Галын аюулгүй байдлын журам.

MONCON "MONCON CONSTRUCTION" LLC
FOR ALL PROJECTS

Батлав: "МОНКОН КОНСТРАКШН" ХХК-ий
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: Г. БАТБАЯР

УХН1025 8378802

"МОНКОН КОНСТРАКШН" ХХК-ий
ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЖУРАМ

Хамрах хүрээ: Нийт төсөл болон алба, хэлэлцлийн хүрээнд
Дугаар №:

УЛААНБААТАР ХОТ 2019 ОН

MONCON "MONCON CONSTRUCTION" LLC
FOR ALL PROJECTS

БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ / DOCUMENT CONTROL

Баримтын мэдээлэл / Document Information

Тайлбар / Information	Мэдээлэл / Information
Баримт бичгийн эзэмшигч	Хөдөлмөрчин аюулгүй байдлыг эргүүлж оруулах
Анх хэвлэгдсэн огноо	2018.02.20
Сүүлд хэвлэгдсэн огноо	2019.04.15
Баримт бичгийн нэр	Галын аюулгүй байдлын журам

Баримтын түүх / Document History

Хувилбар / Version	Батлагдсан өдөр / Issue Date	Өөрчлөлт / Changes
1.0	2019.04.16	ХАБЭА-н алба батлууруулж өгсөн.

Баталгаажуулсан / Document Approvals

Албан тушаал / Role	Нэр / Name	Гарын үсэг / Signature	Огноо / Date
Хянасан:			
ХАБЭА-н албаны дарга	Д.Мөнхбат		
Батлууруулсан:			
ХАБЭА-н ахлах ажилтан	Ц.Цэндсүрэн		

10. Төслийн хугацаанд барилгын ажил явагдаж талбайд гал гарсан тохиолдол бүртгэгдээгүй. Хэрэв гарсан тохиолдолд анхан шатны унтраах арга хэмжээ авах, Онцгой байдлын албанд мэдээлэх арга хэмжээг авч ажиллах болно.
11. Гал унтраах хэрэгслийг төслийн талбайд объект тус бүрт байршуулан ажилласан. Байршуулахдаа ил талбайд хэрэглэхэд саад үл болох талбайд байршуулах ажлыг зохион байгуулсан. Галын хорыг “Эрчим гал” ХХК-иар гэрээ байгуулан хамтран ажилладаг. (Галын хор цэнэглэсэн зардал 280 000.00).

Зураг-8.5. Төслийн талбайд гал унтраах хэрэгсэл байршуулсан байдал /галын сараа, гал унтраагуур/





